



БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ 2017

“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК



2016 ОН

АГУУЛГА

1. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА
 - 1.1. Макро орчны тойм
 - 1.2. Даатгалын зах зээлийн ерөнхий төлөв байдал
 - 1.3. Хөдөө аж ахуйн салбарын судалгаа
2. КОМПАНИ
 - 2.1. Компанийн танилцуулга
 - 2.2. Компанийн зорилго, зорилтууд
 - 2.3. Компанийн засаглалын тухай
3. БҮТЭЭГДЭХҮҮН
 - 3.1. Бүтээгдэхүүний судалгаа, ирэх оны төлөв
 - 3.1.1. Малын индексжүүлсэн даатгал
 - 3.1.2. Газар тариалангийн индексжүүлсэн даатгал
 - 3.1.3. Эрчимжсэн мал аж ахуйн даатгал
 - 3.2. Бүтээгдэхүүний судалгаа
4. МАРКЕТИНГИЙН СТРАТЕГИ
 - 4.1. Даатгалын борлуулалтын сувгийн стратеги
 - 4.2. Маркетингийн стратеги, иж бүрдлийн хөтөлбөр
5. МЕНЕЖЕМЕНТ
 - 5.1. Компанийн зохион байгуулалт
 - 5.2. Удирдлагын багийн бүрэлдэхүүн, тэдний үүрэг хариуцлага
6. САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
 - 6.1. Зарлагын тооцоо
 - 6.2. Орлогын тооцоо
 - 6.3. Ашиг алдагдалын тооцоо
7. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ
 - 7.1. Эдийн засаг улс төрийн эрсдэл
 - 7.2. Хууль эрх зүйн орчны эрсдэл
8. ДҮГНЭЛТ

1. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

1.1. Макро орчны тойм

Дэлхийн эдийн засгийн төлөв, түүний төсөөлөл

Олон улсын валютын сан хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтийн таамаглалыг 2016 онд 4.1 хувь, 2017 онд 4.6 хувь байхаар төсөөлжээ. ОУВС-ийн дүгнэж байгаагаар бол эдийн засгийн өсөлтийн гол асуудал нь Хятадын дотоодын эдийн засгийн өсөлтийн тэнцвэргүй байдал, түүхий эд экспортлогч орнуудын тулгамдаж буй асуудал болох түүхий эдийн үнийн уналт, мөн АНУ-ын холбооны нөөцийн хүүгээс тогтоосон үнэ зэргээс шалтгаалж байна гэж үзэж байна.

БНХАУ-ын Засгийн газраас хөрөнгө оруулалтад суурилсан эдийн засгаас дотоодын хэрэглээнд суурилсан эдийн засагт шилжих бүтцийн өөрчлөлтийн бодлого баримталж, 2016 оны эдийн засгийн өсөлтөө 6.5 орчим хувь байна гэж таамаглажээ. Харин БНХАУ-ын эдийн засаг 2016 оны эхний хагас жилийн байдлаар 6.7 хувиар өссөн нь шинжээчдийн таамаглалаас давсан. Эдийн засгийн өсөлт төсөөлж байснаас өндөр гарсан нь жижиглэн худалдаа болон аж үйлдвэрийн салбарын гарц төсөөлж байснаас өндөр гарсантай холбоотой. Мөн БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2017-2018 онд үргэлжлэн буурах төлөвтэйг анхааруулсан.

Евро бүсийн эдийн засаг 2015 онд 1.7 хувиар өссөн. Европын холбооны гишүүн орнуудаас Герман улсын эдийн засаг 1.5 хувь, Франц улсын эдийн засаг 1.3 хувь, Испани улсын эдийн засаг 3.2 хувь, Итали улсын эдийн засаг 0.8 хувиар өссөн бол Унгар улсын эдийн засаг 0.8 хувиар буурсан. Герман, Франц, Итали, Испани зэрэг орнуудын эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор Евро бүсийн эдийн засаг 2016 онд 1.6 хувиар өсөх төлөвтэй байна.

Харин Европын холбооны гишүүн орнуудад хэрэгжүүлж буй хөдөлмөрийн зах зээлийн шинэтгэлийн бодлогын үр дүнд 2015 онд 10.9 хувь байсан ажилгүйдлийн түвшин 2016 онд 10.3 хувь, 2017 онд 9.9 хувь болж буурахаар хүлээгдэж байна.

Японы төв банк 2016 оны 7 дугаар сард бодлогын хүүгээ хасах 0.1 хувьд хэвээр үлдээх шийдвэр гаргасан бол Японы ерөнхий сайд Шинзо Абэ иений нийлүүлэлтээ нэмэгдүүлэхээ зарлаад байна. АНУ-ын Төв банкны “Мөнгөний бодлогын зөвлөл” 2016 оны 4 сард хуралдаж хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтийн тогтвортой байдал, инфляц зорилтот түвшнээс доогуур байгааг харгалзан бодлогын хүүг хэвээр үлдээх шийдвэр гаргасан.

Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага

Зэс: БНХАУ дэлхийн нийт зэсийн хэрэглээний 50 орчим хувийг эзэлдэг бөгөөд 2016 оны эхний 7 сарын байдлаар зэсийн баяжмалын импорт 2015 оны мөн үеэс 36 хувиар нэмэгдэж 9.4 сая тоннд, цэвэр зэсийн импорт 20 хувиар нэмэгдэж 3.1 сая тоннд хүрсэн. Гэвч БНХАУ-ын импортын эерэг мэдээлэл нь зэсийн үнийн төлөвт огцом нөлөө үзүүлж чадахгүй байна.

Төмрийн хүдэр: “Олон улсын бизнесийн хяналт” судалгааны байгууллага 2016 онд төмрийн хүдрийн зах зээл зогсонги хэвээр байна гэж таамаглажээ. Дэлхийн томоохон уурхайнууд хямд түүхий эд нийлүүлсээр байгаа, БНХАУ-ын зах зээлд эрэлт буурсаар байгаа болон долларын ханш чангарсан зэрэг нь үүнд голлон нөлөөлөх юм.

Алт: Ирэх онуудад алтны үнэ буурах хандлагатай байна гэж Дэлхийн банкнаас үзэж байна. Энэ нь нэг талаас АНУ-ын Холбооны нөөцийн банкнаас бодлогын хүүгээ нэмэгдүүлэхээр

төлөвлөж байгаа, нөгөө талаас алтны томоохон хэрэглэгчид болох БНХАУ, Энэтхэг улсуудын эрэлт буурч байгаа зэрэгтэй холбоотой юм. Мөн Европын төв банк “Эдийн засгийг дэмжих хөтөлбөр”-өө сунгахгүй гэж мэдэгдсэн нь алтны ханш цаашид унахад нөлөөлж байна.

Нүүрс: БНХАУ-ын олборлосон хэмжээ нь багассантай холбоотойгоор коксжих нүүрсний үнэ дэлхийн зах зээл дээр өссөөр байна.

Эдийн засгийн өсөлт

2016 оны эхний хагас жилийн байдлаар нэрлэсэн ДНБ-ий хэмжээ 10,989.6 тэрбум төгрөгт, бодит өсөлт 1.4 хувьд хүрсэн. Энэхүү өсөлтөд хөдөө аж ахуйн салбар, уул уурхайн салбар, цахилгаан, дулааны салбарын өсөлт эерэг нөлөө үзүүлжээ. Эдийн засгийн идэвхжил багасаж, бараа бүтээгдэхүүний эргэлт сул байгаагаас боловсруулах салбар, худалдаа үйлчилгээний салбар, бүтээгдэхүүний цэвэр татвар бууралттай гарсан.

2016 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр ДНБ-ий бодит өсөлт 1.3 хувь байхаар байгаа бөгөөд үүнд хөдөө аж ахуйн салбар 10.5 хувиар, цахилгаан, дулааны салбар 3.0 хувиар, барилга 0.5 хувиар, бөөний болон жижиглэн худалдааны салбар 2.0 хувиар, тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбар 8.9 хувиар, шууд бус татвар 0.9 хувиар тус тус нэмэгдэхээр байгаа нь голлон нөлөөлж байна. Мөн Оюутолгой ордын баяжмалын хэмжээ 2016 онд 12.5 хувиар өсөхөөр байгаа хэдий ч зэсийн баяжмалд агуулагдах цэвэр зэс, алтны хэмжээ буурахаар байгаа нь 2016 онд уул уурхайн салбарыг 6.9 хувиар бууруулахаар байна.

Хөдөө аж ахуйн салбар

Мал тооллогын урьдчилсан дүнгээр 2016 оны жилийн эцэст улсын хэмжээнд адуу 3.6 сая толгой, үхэр 4.08 сая толгой, тэмээ 401.3 мянган толгой, хонь 27.8 сая толгой, ямаа 27.5 сая толгой буюу нийтдээ 61.5 сая толгой мал тоологдсон нь өмнөх оны 55.6 сая толгой мал тоологдсоноос 9.9 хувиар өссөн үзүүлэлт юм. 2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт төллөх насны 23.9 сая хээлтэгч малын 81.7 хувь буюу 19.5 сая толгой мал төллөөд байна. Нийт гарсан төлийн 97.3 хувь буюу 19.0 сая толгой төл бойжсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Мал төллөлт, зүй бусаар хорогдсон том мал, мян толгой

Үзүүлэлт	2014 I-VI	2015 I-VI	2016 I-VI
Мал төллөлт, хувь	87.1	86.5	81.7
Бойжуулсан төлийн тоо, мян.толгой	16710	18697	19012
Зүй бусаар хорогдсон том мал, мян толгой	300.8	431.8	1236.7
Адуу	17.7	22.5	52.7
Үхэр	27	27.1	119.6
Тэмээ	0.9	1	0.7
Хонь	115	173.3	454
Ямаа	140.2	207.9	609.7

Эх үүсвэр: УСХ

ХХААХҮЯ-наас гаргасан мэдээгээр 2016 оны ургац хураалтын дүнгээр нийтдээ 475.8 мянган тонн үр тариа, үүнээс 460.7 мянган тонн буудай, 153.7 мянган тонн төмс, 93.5 мянган тонн хүнсний ногоо, 19.6 мянган тонн тосны ургамал, 50.6 мянган тонн тэжээлийн ургамал

буюу нэгжээс 14.0 цн улаан буудай, 105.0 цн төмс, 112.1 цн хүнсний ногоо, 17.3 цн тэжээлийн ургамал, 3.1 цн тосны ургамал тус тус хураан аваад байна.

Ажилгүйдлийн түвшин

Ажиллах хүчний түүвэр судалгаанаас үзвэл 2016 оны 2 дугаар улирлын байдлаар эдийн засгийн идэвхтэй хүн ам өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар өсөж, 1263.7 мянгад, ажиллагчдын тоо 1.2 хувиар буурч 1131.8 мянгад хүрсэн бол ажилгүй иргэдийн тоо 35.6 хувиар өсжээ. Ажиллагчдын 41.3 хувь нь Улаанбаатар хотод, 20.7 хувь нь хангайн бүсэд, 16.8 хувь нь төвийн бүсэд, 13.7 хувь нь баруун бүсэд үлдэх 7.5 хувь нь зүүн бүсэд байна.

График 1. Эдийн засгийн өсөлт 2010-2016 он




** - хүлээгдэж буй гүйцэтгэл

Эх сурвалж: ҮСХ, Сангийн яам

Инфляци

2016 оны 8 дугаар сард инфляцын түвшин оны эхнээс 1.2 хувь, жилийн -0.2 хувьтай гарлаа. Үүнд 2015 оны 12 дугаар сараас махны бүлгийн жилийн инфляцын түвшин харьцангуй бага, дийлэнх саруудад үнийн бууралттай байсан нь голлох нөлөөг үзүүлсэн.

График 2. Инфляцийн түвшин, эхний 8 сарын гүйцэтгэл



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2016 оны 8 дугаар сарын байдлаар мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 хувиар өсөж, 11.3 их наяд төгрөгт хүрлээ. Мөнгөний нийлүүлэлтийн 49.4 хувийг төгрөгийн хадгаламж, 22.6 хувийг гадаад валютын хадгаламж, 11.1 хувийг гадаад валютын харилцах, 11.7 хувийг төгрөгийн харилцах, үлдсэн 5.2 хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна. Орон сууцны зээлийн тогтолцоо нь хэрэглээг хумьж, хуримтлалыг нэмэгдүүлснээр инфляц эрс буурсан бас энэ нь мөнгөний хомсдолыг дагуулсан тул иргэдэд хувьцааны мөнгө олгосон. Тэгээд байхад дефляци үүсээд байгаа нь энэ удаагийн хямрал, мөнгөний хомсдолоос үүдэлтэйг харуулж байна.

Төлбөрийн тэнцэл, валютын ханш

2016 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцэл өмнөх оны мөн үеэс 123.6 сая ам.доллараар буурч, 41.3 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Данснуудаар авч үзвэл, урсгал данс 166.2 сая ам.долларын алдагдалтай гарснаар өмнөх оны мөн үеэс 43.0 хувиар буурсан бол хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс 21.8 хувиар буурч, 399.5 сая ам.долларт хүрснээр нийт тэнцэл алдагдалтай гарлаа.

График 3. Төлбөрийн тэнцлийн жил бүрийн эхний 7 сарын гүйцэтгэл /сая ам.доллар/

бүрийн эхний 7 сарын гүйцэтгэл /сая ам.доллар/





График 4. Гадаад валютын нийт албан нөөц, жил бүрийн эхний 7 сар /сая ам.доллар/

нөөц, жил бүрийн эхний 7 сар /сая ам.доллар/




Эх үүсвэр: Монголбанк

Гадаад валютын албан нөөц 2016 оны 7 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 25.3 хувиар, өмнөх сараас 1.6 хувиар буурч, 1275.3 сая ам.долларт хүрлээ.

Монгол Улсын гадаад валютын албан нөөцийг бүрдүүлэгч нэг чухал үзүүлэлт болох Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2016 оны эхний 8 сарын байдлаар 11.7 тн буюу өмнөх оны мөн үеэс 57.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2016 оны эцэст өмнөх оны түвшинтэй харьцуулахад урсгал дансны алдагдал нь нэмэгдэхээр байгаа, мөн хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг нэмэгдэх хандлагатай байгаа нь нийт тэнцлийг алдагдалтай гарахад нөлөөлөхөөр байна. 2017 онд Монгол улсын төлбөрийн тэнцэл 490.0 орчим сая ам.долларын алдагдалтай гарахаар хүлээгдэж байгаа бөгөөд үүнд урсгал данс 825.0 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 436.0 сая ам.долларын ашигтай гарахаар байгаа юм. Оюу-Толгой компани бүтээн байгуулалтын хүрээнд гүний уурхайн санхүүжилтийн эх үүсвэрээс 1.1 тэрбум ам.долларыг 2017 онд ашиглахаар тооцсон.

График 5. Төлбөрийн тэнцлийн хүлээгдэж буй гүйцэтгэл



Эх үүсвэр: Монголбанк, Сангийн яам

Засгийн газар болон хувийн салбарын томоохон зээллэгтэй холбоотойгоор Монгол Улсад орж ирэх валютын урсгал богино хугацаанд нэмэгдэж, улмаар төгрөгийн ханш чангарахад нөлөөлсөн ч 2016 оны 6, 7 дугаар сард төлбөрийн тэнцэл алдагдалтай гарч, улмаар төгрөгийн ханш огцом сулрахад нөлөөлөөд байна. Түүнчлэн импортын эрэлт төдийлөн нэмэгдээгүй буюу импорт агшсан хэвээр байхад валютын ханш өссөн нь валютын зах дахь хүлээлттэй холбоотойгоор төгрөгийн ханш ихээр суларсан байж болзошгүй юм.


Эдийн засгийн 2017-2019 оны төлөв байдлын төсөөлөл

Эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүд болох Оюу-Толгойн далд уурхайн төсөл, Тавантолгойн төсөл /Тавантолгойн төмөр зам орсон/, Гацууртын алтны ордны төсөл, Тавантолгойн 450 мВт-ын цахилгаан станц, ДЦС 3-ыг 250 мВт-аар өргөтгөх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх болон эрчимжүүлэхээр байгаагаас Монгол Улсын эдийн засгийн бодит өсөлт 2017 онд 3.0 хувьд хүрэх төлөвтэй байна. Оюу-Толгойн зэсийн баяжмал, түүнд агуулагдах зэс, алтны агууламж 2016 оноос эхлэн багасаж байгаатай холбогдон уул уурхайн салбар 2017 онд 4.4 хувиар буурах хандлагатай байгаа юм. 2017 онд цахилгаан дулааны салбар 3 хувиар өсөхөөр байгаа нь эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхээр байна. Өмнөх онуудад цахилгаан дулааны салбарт хийсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор 2014 онд ашиглалтад оруулсан

ДЦС 3, 4-ийн өргөтгөл, 2015 онд ашиглалтад оруулсан Амгалан ДЦС бүрэн хүчин чадлаараа ажиллахаар тооцоолж байгаатай холбоотой.

2017 онд зэс, молибдени, газрын тосноос бусад уул уурхайн салбарын бүтээгдэхүүнүүд болох нүүрс 16.3 хувиар, боловсруулах аж үйлдвэрийн салбар 5.7 хувиар тус тус өсөхөөр тооцоологдож байгаагаас тээвэр агуулахын үйлчилгээний салбар 10.1 хувиар, бөөний болон жижиглэн худалдааны салбар 5.1 хувиар, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбар 3.1 хувиар тус тус өсөж үйлчилгээний салбар нийт дүнгээрээ 4.7 хувиар өсөхөөр байна. Дээрх төсөл хөтөлбөрүүдийн бүтээн байгуулалттай холбоотой хөрөнгө оруулалт нэмэгдэж 2017 онд барилгын салбарыг 3.6 хувиар өсөхөөр тооцоолсон. Дунд хугацаанд уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүдийн бүтээн байгуулалтын ажил хийгдэж хөрөнгө оруулалт нэмэгдэхээр тооцоолсны үндсэн дээр барилга, бөөний болон жижиглэн худалдааны салбар, тээвэр агуулахын үйл ажиллагааны салбар зэрэг уул уурхайн бус салбарын өсөлт ирэх жилүүдэд нэмэгдэж Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2019 онд 7.1 хувьд хүрэх хандлагатай байна.

График 6. Эдийн засгийн өсөлт болон ДНБ-ий хэмжээ



Эх үүсвэр: Сангийн яам

Хүснэгт 2. Эдийн засгийн өсөлт, салбараар


Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
	Гүйц	Гүйц	Урьд. Гүйц	ХБГ	Төсөөлөл		
Эдийн засгийн бодит өсөлт	11.6	7.9	2.4	1.3	3.0	5.1	7.1
1 Уул уурхайн салбарын бодит өсөлт	19.4	19.4	14.1	-6.9	-4.3	1.3	11.1
2 Уул уурхайн бус салбарын бодит өсөлт	9.8	5.0	-1.0	4.0	5.2	6.1	6.1
3 Хөдөө аж ахуйн салбарын бодит өсөлт	19.3	13.7	10.7	10.5	9.1	8.3	7.8

4	Үйлдвэрлэлийн салбарын бодит өсөлт	15.3	12.7	9.7	-6.9	-1.4	3.5	10.1
5	Үйлчилгээний салбарын бодит өсөлт	6.8	7.8	1.0	3.5	4.7	5.6	5.5

Гадаад худалдаа

2017 онд гадаад худалдааны нийт эргэлт 7.2 тэрбум ам.долларт, гадаад худалдааны нийт тэнцэл 374.5 сая ам.долларын ашигтай гарахаар байна. Гадаад худалдааны нийт эргэлт 2018 онд 7.8 хувиар өсөж 7.8 тэрбум ам.долларт, 2019 онд 7.5 хувиар өсөж 8.4 тэрбум ам.долларт тус тус хүрэхээр байна.

График 7. Гадаад худалдаа, 2017-2019 оны төсөөлөл, сая ам.доллар



* хүлээгдэж буй гүйцэтгэл ** төсөөлөл


Эх үүсвэр: Сангийн яам

Экспорт

Экспортоор 2016 оны 8 сард 3.0 тэрбум ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7.9 хувиар буурсан үзүүлэлт юм. Экспортын барааны нийт дүнд:

- Эрдэс бүтээгдэхүүн болон сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс 2525.5 сая ам.доллар буюу 84.0 хувь;
- Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн 224.7 сая ам.доллар буюу 7.5 хувь;
- Авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 65.6 сая ам.доллар буюу 2.2 хувь;
- Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн 51.3 сая ам.доллар буюу 1.7 хувь;
- Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд анги 49.1 сая ам.доллар буюу 1.6 хувь;
- Ургамлын гаралтай бүтээгдэхүүн 29.5 сая ам.доллар буюу 0.9 хувь;
- Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл 17.0 сая ам. доллар буюу 0.7 хувь;
- Бусад бүтээгдэхүүн 1.4 хувийг тус тус эзэлж байна.

График 8. Гадаад худалдааны нийт бараа эргэлт, сая ам.доллар



Эх үүсвэр: ҮСХ

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт 4.1 хувь, импорт 4.5 тэрбум ам.доллар, экспорт 5.3 тэрбум ам.доллар байхаар тооцож, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогыг 2015 оны гүйцэтгэлээс 17.3 хувиар өсгөж, 7,013.9 тэрбум төгрөгт хүрнэ гэж тусгасан байсан. Гэвч 2016 эхний 8 сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 3,562.4 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 785.4 тэрбум төгрөгөөр тасарсан. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, дэлхийн зах зээл дээрх зэс, нүүрс зэрэг зарим нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүний үнийн уналт, импортын бууралт болон татварын бус орлогын төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй зэрэг шалтгааны улмаас төсвийн төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй болно.

1.2. Даатгалын зах зээлийн ерөнхий төлөв байдал

Ерөнхий мэдээлэл

2016 оны 3 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 40, даатгалын хохирол үнэлэгч 29 компани даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Мөн даатгалын компанийн 252 салбар, 10 төлөөлөгчийн газар, даатгалын зуучлагч компанийн 208 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 51 салбар, 2 төлөөлөгчийн газар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт 3. Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	2015-III	2016-III	Өөрчлөлт
1	Ердийн даатгалын компани	15	15	0%
2	Урт хугацааны даатгалын компани	1	1	0%
3	Давхар даатгалын компани	1	1	0%
4	Даатгалын төлөөлөгч	3314	3020	-9%
5	Даатгалын зуучлагч	34	40	18%
6	Даатгалын хохирол үнэлэгч	24	29	21%
7	Актуарч	15	15	0%

8	Даатгалын үйл ажиллагаанд аудит хийх эрх бүхий аудитын компани	20	41	105%
	БҮГД	3424	3286	-4%


Хүснэгт 4. Даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогч компаниудын салбарын тоо

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	2015-III	2016-III	Өөрчлөлт
1	Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газар	255	252	-1%
2	Даатгалын зуучлагч компанийн салбар	168	208	24%
3	Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар, төлөөлөгчийн газар	52	51	-2%
	БҮГД	475	511	8%

Даатгагчийн хөрөнгө

2016 оны 3-р улирлын байдлаар давхар даатгалын болон даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 207.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 37.8 тэрбум төгрөгөөр буюу 22.3 хувиар өссөн байна.

График 9. Давхар даатгалын болон даатгалын компаниудын нийт хөрөнгө, түүний өсөлт




Даатгалын ангилалыг салбарын хэмжээндэх нийт хөрөнгөд эзлэх хувиар авч үзвэл ердийн даатгалын компаниудын хөрөнгө 80.5 хувь, давхар даатгалын компани 15.9 хувь, урт хугацааны даатгалын компани 3.6 хувийг тус тус эзэлж байна. Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө, салбарт эзлэх хувийг тооцвол “Монгол даатгал” ХХК 36.97 тэр бум төгрөгийн нийт хөрөнгөөр тэргүүлж удаах байранд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК 32.96 тэр бум төгрөг, “Тэнгэр даатгал” ХХК 15.78 тэр бум төгрөг, “Мандал генерал даатгал” ХХК 14.02 тэр бум төгрөгийн хөрөнгөтэй байна.

Даатгагчийн өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

2016 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын болон давхар даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нөөц сан 24.3 тэрбум төгрөгөөр буурч, өр төлбөр 47.1 тэрбум төгрөгөөр, эзэмшигчдийн өмч 15.0 тэрбум

төгрөгөөр тус тус өссөн байна. Компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг дараах дүрслэл, хүснэгтүүдэд дэлгэрэнгүй харуулав.

График 10. Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч /тэрбум




Хүснэгт 5.

Үзүүлэлт	2015.III		2016.III		Өсөлт/бууралт	
	төгрөгөөр	эзлэх хувь	төгрөгөөр	эзлэх хувь	төгрөгөөр	эзлэх хувь
Өр төлбөр	5,619,575,731.2	3.3%	52,724,802,644.4	25.4%	47,105,226,913.1	125%
Нөөц сан	73,841,962,708.8	43.5%	49,538,354,622.8	23.9%	24,303,608,086.0	-64%
Эзэмшигчдийн өмч	90,132,180,245.9	53.1%	105,148,879,428.1	50.7%	15,016,699,182.1	40%
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	169,593,718,686.1	100.0%	207,412,036,695.2	100.0%	37,818,318,009.2	100%

Даатгалын хураамж

2016 оны 3-р улирлын байдлаар даатгалын компаниуд 633,053 иргэд, албан байгууллагуудтай даатгалын гэрээ байгуулж, 88.7 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн байна. Даатгалын хураамжийн нийт орлогын 99.0 хувь буюу 87.8 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 1.0 хувь буюу 0.93 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани төвлөрүүлсэн байна. Даатгалын компаниуд даатгалын хураамжийн нийт орлогынхоо 30.3 хувь буюу 26.9 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид шилжүүлсэн байна. Энэхүү тайлант хугацааны даатгалын хураамжийн нийт орлого нь өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар буурсан байна.

График 11. Даатгалын хураамжийн нийт орлого, давхар даатгалын хураамж /тэрбум төгрөг/



2016 оны 3-р улирлын байдлаар даатгалын хураамжийн нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулан даатгалын хэлбэр тус бүрээр авч үзвэл хөрөнгийн даатгал, ачааны даатгал, барилга угсралтын даатгал, газар тариалангийн даатгал, мал амьтдын даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, итгэлцлийн даатгалын хэлбэрээр тус тус нийт хураамжийн орлогын дүнд нөлөөлхүйц өссөн үзүүлэлттэй байна. Даатгалын хураамжийн нийт орлогын бүтцэд хөрөнгийн даатгал 30.3 хувь, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 25.2 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 12.8 хувь, гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал 10.4 хувь, бусад даатгалын хэлбэрүүд 21.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт 6. Даатгалын хураамжийн нийт орлого /хэлбэрээр/

№	Үзүүлэлт	Даатгалын нийт хураамжийн орлого		Өсөлт, бууралт / хувиар/
		2015.III	2016.III	
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	8,465,675,953.1	9,270,250,368.1	9.5%
2	Хөрөнгийн даатгал	20,999,367,238.3	26,886,180,276.3	28.0%
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	11,922,634,964.9	11,352,789,381.9	-4.8%
4	Ачааны даатгал	1,069,286,476.8	1,405,738,391.2	31.5%
5	Барилга угсралтын даатгал	439,307,321.7	1,845,174,589.6	320.0%
6	Газар тариалангийн даатгал	-	13,699,146.0	100.0%
7	Мал амьтдын даатгал	478,322,456.4	669,887,663.3	40.0%
8	Агаарын хөлгийн даатгал	2,819,785,648.7	2,525,105,580.5	-10.5%
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	282,031,525.7	313,084,263.7	11.0%
10	Хариуцлагын даатгал	4,798,820,413.4	5,018,596,515.5	4.6%
11	Санхүүгийн даатгал	2,728,672,576.2	2,682,534,614.5	-1.7%
12	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	17,998,656,269.1	22,354,498,179.1	24.2%
13	Зээлийн даатгал	577,776,242.5	637,125,413.6	10.3%
14	Итгэлцлийн даатгал	12,847,354.0	279,282,541.6	2073.9%
15	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	-	-	-

16	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	-	-	-
17	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	15,204,880,447.6	2,604,442,995.2	-82.9%
18	Хугацаат амьдралын даатгал	271,740,562.8	115,149,295.6	-57.6%
19	Насан туршийн даатгал	-		
20	Хуримтлалын даатгал	63,092,929.5	60,561,681.0	-4.0%
21	Тэтгэврийн даатгал	39,597,893.4	40,212,809.0	1.6%
22	Эрүүл мэндийн даатгал	931,370,708.9	712,934,620.4	-23.5%
23	Аннуити даатгал	-	-	-
	Дүн	89,103,866,983.0	88,787,248,325.9	130.0%

2016 оны 3-р улирлын байдлаар даатгалын хураамжийн нийт орлогын 39.5 хувь буюу 38.0 тэрбум төгрөгийг даатгалын төлөөлөгч, 17.0 хувь буюу 15.1 тэрбум төгрөгийг даатгалын зуучлагч нар төвлөрүүлсэн байна.

Даатгалын нөхөн төлбөр

2016 оны 3-р улирлын байдлаар даатгалын компаниуд 46079 иргэд, байгууллагуудад 24.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосноос 1.57 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг гадаадын давхар даатгагчаас олгосон байна. Нийт даатгалын нөхөн төлбөрийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.0 хувиар буурсан бөгөөд салбарын дүнгээр хохирол нөхөлтийн харьцаа 29.02 хувьтай байна.

Тайлант хугацааны нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр нь авч үзвэл нийт нөхөн төлбөрийн 44.1 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, 23.0 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 32.9 хувийг бусад даатгалын хэлбэр эзэлж байна.

Хүснэгт 7. Нөхөн төлбөр, даатгалын хэлбэр тус бүрээр

№	Даатгалын хэлбэр	Нөхөн төлбөр	
		2015.09.30	2016.09.30
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	2,761,633,857.6	2,411,038,581.9
2	Хөрөнгийн даатгал	1,852,879,856.7	1,883,420,420.3
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	6,620,645,740.7	5,550,496,311.4
4	Ачааны даатгал	211,877,122.8	175,396,008.8
5	Барилга угсралтын даатгал	1,538,322,250.1	19,542,580.0
6	Мал амьтдын даатгал	45,619,243.7	174,197,167.2
7	Агаарын хөлгийн даатгал	-	110,982,500.0
8	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	22,676,583.0	13,139,118.0
9	Хариуцлагын даатгал	249,681,455.2	466,405,557.9
10	Санхүүгийн даатгал	1,189,955,802.3	1,564,700,457.2
11	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	10,594,084,223.1	10,652,333,950.6
12	Зээлийн даатгал	2,010,757,171.4	499,340,033.5
13	Итгэлцлийн даатгал	5,104,891.0	21,250,000.0


14	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	11,326,352.8	9,520,751.1
15	Хугацаат амьдралын даатгал	80,509,900.1	65,299,630.2
16	Хуримтлалын даатгал	71,393,144.5	72,915,242.0
17	Тэтгэврийн даатгал	30,368,575.0	11,459,120.0
18	Эрүүл мэндийн даатгал	509,340,874.2	468,095,884.4
	Дүн	27,806,177,044.0	24,169,533,314.4

Жич: Тайлант хугацаанд нөхөн төлбөр олгогдоогүй даатгалын хэлбэрүүдийг дээрх хүснэгтэд оруулаагүй болно.

Даатгалын нөөц сан

2016 оны 3-р улирлын байдлаар даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ 49.5 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 32.9 хувиар буурсан байна.


График 12. Нөөц сангийн хэмжээ, өсөлт



Даатгалын хохирлын харьцаа

2016 оны 3-р улирлын байдлаар салбарын хэмжээндэх нийт хохирлын харьцаа 29.0 хувьтай байна. Энд давхар даатгалд төлсөн хураамж болон давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийг нэмж тооцсон болно. Мөн даатгагчийн орлогод тооцсон хураамж, даатгагчаас олгосон нөхөн төлбөрийн харьцаагаар тооцоход салбарын хэмжээнд хохирлын харьцаа 38.9 хувьтай байна.

График 13. Даатгалын хохирлын харьцаа




Давхар даатгал

2016 оны 3-р улирлын байдлаар ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд гадаадын давхар даатгагчид нийт 26.9 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамж төлсөн нь даатгалын хураамжийн нийт орлогын 30.3 хувийг эзэлж байна. “Бодь даатгал” ХХК-ийн хувьд давхар даатгалд төлсөн хураамж нь хураамжийн нийт орлогынхоо 66.9 хувийг, “Мандал женерал даатгал” ХХК-ийн хувьд 50.6 хувийг, “Монгол даатгал” ХХК-ийн хувьд 33.9 хувийг эзэлж байгаа нь нийт салбарын үзүүлэлтэд хүчтэй нөлөөлж байна. Тайлант хугацаанд давхар даатгагчаас 1.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь нийт нөхөн төлбөрийн 6.2 орчим хувийг эзэлж байна.

Сүүлийн 5 жилийн 2 дугаар улирлын байдлаар давхар даатгалын хураамж, нөхөн төлбөр, тэдгээрийн харьцааг дараах дүрслэлээр харуулав.

График 14.



Дүгнэлт

Монгол улсын даатгалын салбарын 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг нэгтгэж гол үзүүлэлтүүдийг сүүлийн жилүүдийн мөн үеийн үзүүлэлтүүдтэй харьцууллаа.


Дээрх хугацаанд давхар даатгалын болон даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 207.4 тэрбум төгрөгт хүрч даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нөөц сан 24.3 тэрбум төгрөгөөр буурч, өр төлбөр 47.1 тэрбум төгрөгөөр, эзэмшигчдийн өмч 15.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Нөөц сангийн өсөлтийн шалтгаан нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталснаар 2016 оны 1 дүгээр улирлаас эхлэн ердийн даатгалын компаниуд “Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан”-г “Орлогод тооцоогүй хураамжийн нөөц” гэж санхүүгийн тайланд бүртгэж эхэлсэнтэй холбоотой юм. Тайлант хугацаанд даатгалын компаниуд 88.7 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн нийт орлого төвлөрүүлж, 24.2 тэрбум төгрөгийн нийт нөхөн төлбөр олгосон нь байна.

Давхар даатгалын болон даатгалын компаниудын тайлант үеийн цэвэр ашиг 11.3 тэрбум төгрөг, хуримтлагдсан ашиг 17.6 тэрбум төгрөгт хүрчээ. Даатгагч нарын ашигт ажиллагаанд гол нөлөөлөх харьцаануудыг тооцож үзвэл салбарын хэмжээнд нийт хөрөнгийн өгөөж 28.81 хувь, хөрөнгө оруулалтын өгөөж 4.1 хувь, үндсэн үйл ажиллагааны зардлын харьцаа 41.04 хувь, хохирлын харьцаа 38.98 хувь, зардал ба хохирлын хосолсон харьцаа 80.02 хувьтай байгаа бөгөөд тайлант хугацаанд даатгагч нарын ашигт ажиллагаа өсөхөд хүчтэй нөлөөлж буй нь зардал ба хохирлын хосолсон харьцааны үзүүлэлт юм.

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын хураамжийн нийт орлого ДНБ-ний 0.51 хувийг эзэлж, нэг хүнд ногдох даатгалын нийт хураамжийн орлого 29,0 мянган төгрөг байна. Манай улсын даатгалын салбарын хувьд хөгжлийн гол хэмжүүрүүд болох даатгалын нэвтрэлт, нягтрал нь олон улсын дунджаас харьцангуй доогуур үзүүлэлттэй байдаг бөгөөд эдгээр үзүүлэлтүүдийн хувьд мөн тодорхой өсөлт ажиглагдахгүй байна. Жишээ нь Азийн хөгжлийн банкны судалгаанд дурдсанаар хөгжиж буй зах зээлтэй орнуудын даатгалын салбарын нэвтрэлт дундажаар 2.98%, дэлхийн дундаж 6.9% байдаг байна.

Эдгээр үзүүлэлтүүдийг жилийн эцсийн тоон мэдээлэлд үндэслэж тооцвол бодитой тооцоолол болох хэдийч сүүлийн 5 жилийн 3 дугаар улирлын байдлаар дараах графикт урьдчилсан дүн буюу явцын мэдээллийг өмнөх онуудын мөн үетэй харьцуулсан болно.

График 15. Даатгалын нэвтрэлт, нягтрал



Даатгалын салбарын нэвтрэлт хөгжиж буй зах зээлтэй орнуудын харьцаанаас хэд дахин бага байгаач өмнөх оны мөн үетэй харьцуулхад 0.12% буюу 23.5%-ийн өсөлттэй гарсан нь тайлант хугацаанд тухайн үзүүлэлтэд нөлөөлөхүйц даатгалын хураамжийн өсөлт гараагүйч даатгалд хамрагдсан даатгуулагчидийн тоо өссөн нь түлхэц болсон байна.

1.3. Хөдөө аж ахуйн салбарын судалгаа

Мал тооллогын урьдчилсан дүнгээр 2016 оны жилийн эцэст улсын хэмжээнд адуу 3.6 сая толгой, үхэр 4.08 сая толгой, тэмээ 401.3 мянган толгой, хонь 27.8 сая толгой, ямаа 27.5 сая толгой буюу нийтдээ 61.5 сая толгой мал тоологдсон нь өмнөх оны 55.6 сая толгой мал тоологдсоноос 9.9 хувиар өссөн үзүүлэлт юм. 2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт төллөх насны 23.9 сая хээлтэгч малын 81.7 хувь буюу 19.5 сая толгой мал төллөөд байна. Нийт гарсан төлийн 97.3 хувь буюу 19.0 сая толгой төл бойжсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 хувиар нэмэгдсэн байна.

Мал аж ахуй

2016 оны эхний хагас жилийн түүвэр судалгаагаар улсын хэмжээнд адуу 3.8 сая толгой, үхэр 4.5 сая толгой, тэмээ 432.7 мянган толгой, хонь 32.3 сая толгой, ямаа 29.2 сая толгой буюу нийтдээ 70.2 сая толгой мал тоологдсон нь өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар өссөн үзүүлэлт юм. 2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт төллөх насны 23.9 сая хээлтэгч малын 81.7 хувь буюу 19.5 сая толгой мал төллөөд байна. Нийт гарсан төлийн 97.3 хувь буюу 19.0 сая толгой төл бойжсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 хувиар нэмэгдсэн байна.

Малчдын дундаж орлого

Мал бүхий өрх, малчид: 2015 оны мал тооллогын дүнгээр улсын хэмжээгээр, мал бүхий 216.7 мянган өрх тоологдсон байна. Үүний 69.2 хувь буюу 145.3 мянган өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа малладаг, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 30.8 хувь буюу 64.6 мянган өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй малтай өрх байна.

2014 оны малын тооллогын дүнгээр 285.7 мянган малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа бөгөөд малчдыг насны бүлгээр авч үзвэл 38.5 хувь нь 15-34 насны, 51.8 хувь

нь 35 наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насныхан, 9.7 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Сүүлийн жилүүдэд малчдын дотор 15-34 насны залуу малчдын эзлэх хувийн жин буурч, харин 35 наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насныхны эзлэх хувийн жин өссөн хэвээр байна.


Малчдын нийгэм ахуйн зарим үзүүлэлт.

2015 оны мал тооллогоор нийт малчин өрхийн 84.1 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 74.1 хувь нь телевизортой, 38.4 хувь нь автомашинтай, 47.2 хувь нь мотоциклтой, 3.3 хувь нь трактортой гэсэн дүн гарлаа.

Цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо 2014 онд 122.3 мянга болж, өмнөх оныхоос 2.5 мянгаар буюу 2.1 хувь, автомашинтай өрхийн тоо 14.6 мянга буюу 35.4 хувь, мотоциклтой өрхийн тоо 5.6 мянга буюу 8.9 хувиар өсч, телевизортой өрхийн тоо 1.1 мянга буюу 1.0 хувиар буурчээ.

Мал бүхий 216.7 мянган өрхийг малын тоогоор нь бүлэглэвэл, 6.6 хувь буюу 14.2 мянга нь 10 хүртэл малтай; 9.2 хувь нь буюу 19.9 мянга нь 11-30 малтай; 7.1 хувь буюу 15.5 мянга нь 31-50 малтай; 13.5 хувь буюу 29.3 мянга нь 51-100 малтай; 21.3 хувь буюу 46.2 мянга нь 101-200 малтай; 27.7 хувь буюу 60.1 мянга нь 201-500 малтай; 10.6 хувь буюу 23.0 мянга нь 500-гаас дээш малтай өрх байна.

График 16. Малчдын тоо, эзэмшиж буй малын тоогоор (мянгаар)



Нийт малчин өрхийн 57.7% нь 200 хүртэлх малтай ба жилд дунджаар 5.0 сая төгрөг, 27.7% нь 500 хүртэлх малтай бөгөөд жилд дунджаар 12.0 сая төгрөг, 3.9 хувь нь 1000-аас дээш малтай ба жилд дунджаар 52 сая төгрөгийн орлоготой. Малчдын дундаж орлогыг хүснэгтээр үзүүлвэл:

Хүснэгт 9. Малчдын орлогын эх үүсвэрийн задаргаа

	Ноос ноолуур, арьс ширнээс олох орлого	Мал махнаас олох орлого	Сүү, цагаан идээнээс олох орлого	Нийт орлого
200 толгой малтай өрх	₮ 1,065,000	₮ 1,779,000	₮ 1,920,000	₮ 4,765,000
500 толгой малтай өрх	₮ 3,430,000	₮ 5,595,000	₮ 2,400,000	₮ 11,426,000

1000-аас дээш толгой малтай өрх	₮ 15,933,000	₮ 30,992,000	₮ 4,720,000	₮ 51,645,000
------------------------------------	-----------------	-----------------	----------------	-----------------

2016 онд малчдын орлогын эх үүсвэр болох малын түүхий эд, махны үнэ уналттай байсан нь малчдын орлогод шууд нөлөөлсөн, мөн энэ байдал нь 2017 онд үргэлжлэх төлөвтэй тул малчдын орлого буурахаар байна.

Газар тариалан

Хөдөө аж ахуйн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 14 хувийг, үүнээс 20 хувийг газар тариалангийн салбар бүрдүүлж байна. Монгол улсын нийт тариалсан талбайн хэмжээг сүүлийн дөрвөн жилээр авч үзвэл 2013 онд 291,9 мянган га, 2014 онд 315,9 мянган га, 2015 онд 389,7 мянган га, 2016 онд 377,3 мянган га талбайд тус тус тариалалт хийсэн байна.

Газар тариалангийн бүтээгдэхүүнийг тус бүрээр нь тариалсан талбайн хэмжээ, ургац хураалтын талаарх тоон баримтыг доорх хүснэгтээр харуулав.


Хүснэгт 10. Ургац хураалт, үр тарианы хэлбэрээр

№	Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2013	2014	2015	2016
		Тариалсан талбай /мянган га/				Ургац хураалт /мянган тонн/			
1	Үр тариа	291,9	315,9	389,7	377,3	388,8	518,8	215,7	475,9
1.1	Үүнээс: Буудай	275,0	293,4	361,6	355,4	370,4	489,4	204,0	460,8
1.2	Овьёос	6,5	10,0	12,0	7,2	9,7	17,0	3,2	7,5
1.3	Арвай	3,8	6,4	6,1	6,7	4,5	8,2	2,4	6,2
2	Малын тэжээл	12,0	15,3	20,1	28,2	4,4	40,4	50,4	50,7
3	Рапс	79,4	80,4	79,1	63,9	42,7	51,8	22,5	19,6
4	Төмс	15,2	13,3	12,7	14,6	190,6	164,1	165,8	153,8
5	Хүнсний ногоо	8,1	8,3	6,8	8,3	102,3	102,2	72,7	93,5

Эх үүсвэр: ХХААХҮЯам

Газар тариалангийн салбарт улаан буудай нь нийт газар тариалангийн 73 хувийг, үүнээс үр тарианы 90 гаруй хувийг дангаар эзэлж, Монгол улсын стратегийн хүнс, үндэсний аюулгүй байдлын баталгаа гэж төрөөс үзэж байгаа юм.

График 17. Нийт тариалсан талбайд үр тариа, бусад ургамлын эзлэх хувь



Улаан буудай тариалж буй талбайн хэмжээ нь бусад үр тариа, төмс, хүнсний ногоо зэргийн талбайн хэмжээтэй харьцуулахад харьцангуй том төдийгүй төмс, хүнсний ногооны талбайд усжуулалт харьцангуй их хийгддэг тул улаан буудай шиг ган гачигийн эрсдэл их тохиолддоггүй байна. Жишээлбэл, 2015 оны намар Монгол улс нийт хурааж авахаар төлөвлөсөн улаан буудайн ургацынхаа 60-70 хувийг алдаж, хохирол хүлээсэн байна.

Мөн газар тариалангийн салбар бол хуурай сэрүүн, эрс тэс уур амьсгалтай манай улсын хувьд ихээхэн эмзэг салбар тул энэ салбарт ажиллагсдын бизнес мөн адил ихээхэн эрсдэлтэй байдаг. Иймд тариалан эрхлэгчид өөрсдийн тариалангаа даатгуулах сонирхолтой байдаг хэдий ч арилжааны даатгалын компаниуд эрсдэлийг дангаар хариуцаж хүчрэхгүй тул эрэлтийг хангах нийлүүлэлт байхгүй байсаар байна.

“Үрийн тариалангийн даатгалын тухай” хуулийг 1999 онд баталсан. Хуулинд улаан буудайн үрийн тариаланг байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах зорилгоор жил бүр заавал даатгаж байхаар тусгаж, хуулинд 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч өнөөг хүртэл хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа юм.

Энэ мэт бэрхшээлээс тариаланчид болон стратегийн бүтээгдэхүүн болох улаан буудайг даатгалын аргаар хамгаалж, эрсдэл тулгарсан үед эдийн засгийн урьдчилсан хамгаалалтыг үзүүлэх шаардлагатай байгаа тул “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-аас улаан буудайг даатгах ажлыг 2016 оноос туршилтын журмаар эхлүүлээд байна.

Газар тариаланчдын дундаж орлого

Улсын хэмжээгээр 2015 онд нийт 519.5 мян.га талбайд тариалалт хийснээс 390.7 мян.га-д үр тариа, 12.8 мян.га-д төмс, 7.7 мян. га-д хүнсний ногоо, 23.8 мян.га-д тэжээлийн ургамал, 84.5 мян.га-д техникийн ургамал тариалсан нь өмнөх оныхоос нийт тариалсан талбай 78.9 мян.га буюу 17.9 хувиар нэмэгдсэн байна.

Үр тариа 216.3 мян.т, төмс 163.8 мян.т, хүнсний ногоо 72.3 мян.т-ыг 2015 онд хураан авч, 1028.7 мян.т хадлан, 39.9 мян.т гар тэжээл бэлтгэсэн байна. Өмнөх оныхоос үр тариа 302.5 мян.т буюу 58.3 хувь, хадлан 150.0 мян.т буюу 12.7 хувь, хүнсний ногоо 32.4 мян.т буюу 31.0 хувь, гар тэжээл 0.4 мян.т буюу 0.9 хувиар буурч, төмс 2.3 мян.т буюу 1.4 хувиар өссөн байна. Нэг га-гаас 5.5 цн үр тариа, 127.5 цн төмс хураасан нь өмнөх оныхоос үр тарианых 11.0 цн буюу 66.7 хувиар буурч, төмснийх 5.2 цн буюу 4.3 хувиар өссөн байна.

Газар тариалан эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж:

2014 оны байдлаар ХАА-н салбарт ажиллаж буй нийт өрхийн 86,2 хувь нь мал аж ахуйн салбар, 13,8 хувь нь газар тариалангийн салбарт ажиллаж байна.

Хүснэгт 11. Газар тариалан эрхэлдэг өрх, аж ахуйн нэгжийн тоо

№	ХАА-н салбар	Нийт	Өрх	Аж ахуйн нэгж байгууллага
1	Мал аж ахуй	210,070	209,563	507
2	Газар тариалан	35,166	33,461	1,705
3	Ойн аж ахуй	232	0	232
4	Ан агнуурын аж ахуй	2	0	2
5	Загасны аж ахуй	9	0	9

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2014 оны байдлаар газар тариалан эрхэлдэг нийт 33461 өрх, 1705 аж ахуйн нэгж байна. Манай улсын нийт өрхийн 3,5 хувь нь газар тариалан эрхэлж байна.

Хүснэгт 12. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг өрх болон аж ахуйн нэгжийн даатгалд хамрагдсан байдал

	Нийт өрх, ААН-ын тоо	Даатгалд хамрагдсан байдал	Дүнд эзлэх хувь
Өрх	33,461	547	2 хувь
Аж ахуйн нэгж	1,705	119	7 хувь

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Газар тариалан эрхэлдэг өрх болон аж ахуйн нэгжүүд даатгалын үйлчилгээнд хангалтгүй хамрагдаг бөгөөд хангалттай хэмжээний орлогогүй байна.

2. КОМПАНИ

2.1. Компанийн танилцуулга

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд үндэслэн засгийн газрын 280 дугаар тогтоолоор 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдөр байгуулагдсан төрийн өмчийн хувьцаат компани юм. Компани нь Монгол улсад хөдөө аж ахуйн давхар даатгалын тогтолцоог шинээр бий болгох зорилготой.

Компанийн хувьцаа эзэмшигч нь Сангийн яам бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор батлагдсан “Сайн дурын даатгалын хэлбэр”-т заасан “Малын индексжүүлсэн даатгал” (МИД), “Газар тариалангийн даатгал” болон бусад хэлбэрийн даатгалд давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх юм. .

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь малын индексжүүлсэн даатгалын борлуулалтыг хоёр дахь жилдээ зохион байгуулсан бөгөөд 2016 онд газар тариалангийн даатгал (Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгал)-ын бүтээгдэхүүнийг боловсруулж, арилжааны даатгалын компаниудтай хамтран тодорхой сумдад туршилтын журмаар хэрэгжүүлээд байна.

2.2. Компанийн зорилго, зорилтууд

Алсын хараа:

Монгол Улсын даатгалын тогтолцоог олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээгээр хангах

Эрхэм зорилго:

Монгол улсын хөдөө, аж ахуйн салбарыг бүхэлд нь хамарсан эрсдэлийг хамгийн бага түвшинд бууруулах замаар иргэдийн ажил эрхлэлтийг дэмжиж, хөдөө аж ахуй, санхүүгийн салбарын хөгжлийг шинэ шатанд авчрахад оршино.

Үндсэн зорилго:

Даатгагч, даатгуулагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай давхар даатгалын бүтээгдэхүүнийг санал болгон, худалдах замаар оролцогч талуудын нийтлэг эрх ашгийг хамгаалж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг өсгөхөд оршино.

Зорилт:

- Малчдын амьжиргааг зудын эрсдэлээс хамгаалах даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.
- Монгол Улсын давхар даатгалын чиг хандлагыг тодорхойлогч компани байна.
- Дотоодын давхар даатгалын санхүүгийн чадавхийг бэхжүүлнэ.
- Даатгалын зах зээлд тогтвортой оршин тогтнож, байгууллагын санхүүгийн тогтвортой өсөлтийг хангаж ажиллана.
- Олон улсын давхар даатгагчдын гүүр болж, олон улс дахь бизнесийн харилцаагаа өргөжүүлнэ.
- Үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хөдөө аж ахуйн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ.
- Даатгалын чадварлаг боловсон хүчинг бэлтгэнэ.

2.3. Компанийн засаглал

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хувьд Монгол улсын анхны давхар даатгалын компани бөгөөд цаашдаа үйл ажиллагааны цар хүрээгээ улам өргөжүүлэх зорилго тавин ажиллаж байгаагийн хувьд компанийн оновчтой засаглал нь зайлшгүй чухал. Иймд компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос 2014 онд шинэчлэн батлагдсан компанийн засаглалын кодексийг мөрдөн ажиллаж байгаа ба компанийн сайн засаглалыг хөгжүүлснээр хөрөнгө оруулалтын өгөөж, төслийн ашиг нэмэгдэж, хөрөнгийн зах зээлд орж ирэх урсгал идэвхжин, улмаар IPO хийх боломжууд улам бүр нэмэгдэнэ гэж харж байна.

Түүнчлэн компанийн сайн засаглалыг олон улсын жишигт нийцсэн түвшинд хүртэл хөгжүүлснээр байгууллагын бие даасан байдал бэхжиж,
дотооддоо: ТУЗ, хувьцаа эзэмшигч буюу сангийн яам, гүйцэтгэх удирдлага, ажилтнууд,
гадааддаа: хөрөнгө оруулагчид, СЗХ, харилцагч даатгалын компаниуд, банк, хэрэглэгчид гэх мэт үйл ажиллагаанд оролцогч талуудад ил тод, хариуцлагатай, хүртээмжтэй, үр нөлөөтэй, шударга байх гэсэн засаглалын үндсэн зарчмууд хэрэгжиж, тогтвортой, урт

хугацаанд ашигтай ажиллах, зах зээлд үнэ цэнээ олох, хамтын ажиллагааны байгууллага болон хэрэглэгчдэд итгэлцлийг бий болгох үндэс суурийг бий болгох юм.

3. БҮТЭЭГДЭХҮҮН

3.1. Бүтээгдэхүүний судалгаа, ирэх оны төлөв

3.1.1. Малын индексжүүлсэн даатгал

Зуд болон бусад гэнэтийн эрсдэлээс малчдын амьдралын баталгааг хамгаалах зорилгоор Монгол Улсын Засгийн газар Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр МИДТ-ийг 10 жилийн турш амжилттай хэрэгжүүлжээ. МИД нь нэгж малчны малын хорогдлоор бус сумын хэмжээнд малын хорогдлын индекс гаргаж, даатгалын хохирол, нөхөн төлбөрийн хувь хэмжээг тооцоолдог онцлогтой. МИД нь Монгол улс төдийгүй дэлхийн мал аж ахуйд анх удаагаа туршигдаж байгаа даатгалын шинэлэг хэлбэр юм.

МИДТ нь 2005 оноос Баянхонгор, Увс, Хэнтий аймагт анхлан хэрэгжиж, 2010 оноос эхлэн жил бүр аймгийнхаа тоог нэмэх замаар 2012 оноос үндэсний хэмжээд хэрэгжиж эхэлсэн. 2015 оноос МИД-ын ажиллагааг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК үргэлжлүүлэн авч хоёр дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь 2016 оны борлуулалтын улиралд нийт 21 аймаг, Улаанбаатар хотод “Ард даатгал”, “Бодь даатгал”, “Монгол даатгал”, “МИГ даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Хаан даатгал” ХХК-д зуучлалаар Төрийн банк, Хаан банкууд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-тай гэрээ байгуулан МИД-ыг борлуулан ажиллаж, 18,738 малчин өрхийн 4.18 сая толгой малыг даатгалд хамруулж, 1.77 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлсэн байна.

Даатгалын компаниудын борлуулалтын үр дүнг авч үзвэл нийт 18,738 малчин өрхийг даатгалд хамруулснаас 1.56 хувийг “Ард даатгал” ХХК, 20.39 хувийг “Бодь даатгал” ХХК, 12.41 хувийг “Монгол даатгал” ХХК, 6.52 хувийг “МИГ даатгал” ХХК, 8.68 хувийг “Практикал даатгал” ХХК, 6.44 хувийг “Тэнгэр даатгал” ХХК, 2.99 хувийг “Монре даатгал” ХХК, 0.99 хувийг “Хаан даатгал” ХХК, 30.25 хувийг Төрийн банк, 20.39 хувийг Хаан банк тус тус эзэлжээ.

График 18. Даатгалд хамруулсан малчин өрх, дүнд эзлэх хувиар

Ингэснээр өнгөрсөн 10 жилийн хугацаанд давхардсан тоогоор 112,500 орчим малчин өрхийн 20.6 сая толгой малыг даатгалд хамруулж, 9.9 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлжээ. Эдгээрээс 20,000 орчим малчин өрх нийт 3,6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр авч, энэхүү шинэ даатгалын ач тусыг амьдрал дээр бодитойгоор мэдрээд байна. Тэрчлэн малчид нь даатгалд төлсөн хураамжийн хэмжээ, тухайн нутаг оронд гарсан эрсдэлийн хэмжээтэй уялдан харилцан адилгүй нөхөн төлбөрийг авч байна.

Малын индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнд хамрагдсан малчин өрхийн тоо, хураамжийн орлогыг 2006 оноос хойш харахад өссөн дүнгээр нийт 112 мянга орчим малчин өрх даатгалд хамрагдсан ба Засгийн газар болон даатгалын компаниуд хамтран 10,000 гаруй малчин өрхөд нийт 2,7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон юм. Харин тухайн онуудад МИД-д оролцогч даатгалын компаниуд нийт 2,2 тэрбум орчим төгрөгийн ашигтай ажилласан бол зөвхөн энэ онд 250 сая төгрөгийн ашигтай ажиллаад байна. Үүнээс харахад малын даатгал нь эрсдэл өндөртэй салбар хэдий ч даатгалын компаниуд ашигтай ажиллаж болохыг дээрх тоо мэдээ харуулж байна.

2016 онд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь МИД-ын борлуулалтын улиралд нийт 1,774,078,181 төгрөгийн хураамж төвлөрүүлж 39,561,354,020.12 төгрөгийн үнэлгээ мал даатгалд хамруулсан.

МИД-ын 2017 оны борлуулалтын улирал

МИД-ын тухай хуульд зааснаар ҮСХ-ны хагас жилийн мал тооллогын дүнд үндэслэн оролцогч даатгагчдын хурал болон давхар даатгалын компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нөхөн төлбөр олгох тухай шийдвэр гарсан үед давхар даатгалын компанийн гүйцэтгэх захирал нөхөн төлбөр олгох үйл ажиллагааг зохион байгуулна. “Хөдөө Аж ахуйн Давхар Даатгал” ХК оролцогч даатгагчдын дансанд нөхөн төлбөр авах малчдын мэдээлэл болон нөхөн төлбөрт шаардагдах мөнгийг шилжүүлнэ. Даатгагч нөхөн төлбөрийг хүлээн авч даатгуулагчдад олгох нөхөн төлбөрийг даатгалын тохиолдол гарсан сум бүрт байгаа гэрээт арилжааны банкны салбарт шилжүүлэх юм. Компанийн зүгээс хэрэв 2017 оны эхний хагас

жилд малын хохирол Хамтын эрсдэлийн хуримтлалаас хэтрэхгүй нөхөн төлбөр гарсан тохиолдолд дараахи хэмжээгээр 2017 оны эрсдэл даах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөөд байна.

МИД-ын эрсдэлийн дүнд болон дээд түвшний эрсдэл даах чадвар:

Нийт даатгалын хураамж	2,127,145,900.00		
Нийт сонгосон үнэлгээ	47,440,255,600.00		
Эрсдэлийн дунд түвшин	2017	Хуримтлал	Нийт
Хамтын эрсдэлийн сан	957,215,655.00	45,778,506.08	1,002,994,161.08
Дунд түвшний нөөц	106,357,295.00	2,340,481,613.68	2,446,838,908.68
ОУ Давхар Даатгал-дунд	2,765,289,670.00		2,765,289,670.00
			6,215,122,739.76
Эрсдэлийн дээд түвшин			
Дээд түвшний нөөц	337,000,000.00	729,853,790.61	1,066,853,790.61
ОУ Давхар даатгал-Дээд	1,408,975,591.32		1,408,975,591.32
			2,475,829,381.93
Нийт эрсдэл даах чадвар			8,690,952,121.68

Борлуулалтын төлөвлөгөөний дагуу **нийт даатгалын хураамж 2,127,145,900.00 төгрөг**, нийт **сонгосон үнэлгээ 47,440,225,600.00 төгрөг** байх ба үүнээс тооцоолол хийвэл:

Эрсдэлийн дүнд түвшинд: Хамтын эрсдэлийн санд нийт хураамжийн 45 хувь буюу 957,215,655.52 төгрөгийг, дунд түвшний нөөцөд 106,357,295.00 төгрөгийг хуримтлуулах ба ОУ-ын давхар даатгалтай хамт хариуцах нийт эрсдэл нь 6,215,122,739.76 төгрөг байна.

Эрсдэлийн дээд түвшинд: Дээд түвшний нөөцөд 337,000,00.00 төгрөг хуримтлуулж, дээд түвшний олон улсын давхар даатгалтай хамт хариуцах нийт эрсдэл нь 2,475,829,381.93 төгрөг байна.

Нийтдээ дунд болон дээд түвшинд **8,690,952,121.68** төгрөгийн эрсдэлийг даах чадвартай байна.

График 19. МИД-д хамрагдсан малчин өрхийн тоо, 2017 онд хамруулах малчин өрхийн төлөвлөгөө





График 20. МИД-ын бүтээгдэхүүний хураамжийн орлого, олгосон нөхөн төлбөр болон хохирлын харьцаа. 2017 оны төлөвлөгөө /сая төгрөгөөр/



3.1.2. Газар тариалангийн индексжүүлсэн даатгал

Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлийн нэг болох “Газар тариалангийн даатгал”-ын хэлбэр нь Монгол улсын хөдөө аж ахуйн салбарын 80 орчим хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн үйлдвэрлэл давамгайлсан хөдөө аж ахуйтай манай орны хувьд дунд хугацаанд зах зээлийн багтаамж харьцангуй бага тул үндсэн “Малын индексжүүлсэн даатгал”-ын хажуугаар дэмжих чиглэлээр компанийн хураамжийн орлогын багцын диверсификаци хийх боломжтой байна.

Улаан буудай тариалж буй талбайн хэмжээ нь бусад үр тариа, төмс, хүнсний ногоо зэргийн талбайн хэмжээтэй харьцуулахад харьцангуй том төдийгүй төмс, хүнсний ногооны талбайд усжуулалт харьцангуй их хийгддэг тул улаан буудай шиг ган гачгийн эрсдэл их

тохиолддоггүй байна. Жишээлбэл, 2015 оны намар Монгол улс нийт хурааж авахаар төлөвлөсөн улаан буудайн ургацынхаа 60-70 хувийг алдаж, хохирол хүлээсэн байна.

Мөн газар тариалангийн салбар бол хуурай сэрүүн, эрс тэс уур амьсгалтай манай улсын хувьд ихээхэн эмзэг салбар тул энэ салбарт ажиллагсдын бизнес мөн адил ихээхэн эрсдэлтэй байдаг. Иймд тариалан эрхлэгчид өөрсдийн тариалангаа даатгуулах сонирхолтой байдаг хэдий ч арилжааны даатгалын компаниуд эрсдэлийг дангаар хариуцаж хүчрэхгүй тул эрэлтийг хангах нийлүүлэлт байхгүй байсаар байна.

“Үрийн тариалангийн даатгалын тухай” хуулийг 1999 онд баталсан. Хуульд улаан буудайн үрийн тариаланг байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах зорилгоор жил бүр заавал даатгаж байхаар тусгаж, хуульд 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч өнөөг хүртэл хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа юм.

Энэ мэт бэрхшээлээс тариаланчид болон стратегийн бүтээгдэхүүн болох улаан буудайг даатгалын аргаар хамгаалж, эрсдэл тулгарсан үед эдийн засгийн урьдчилсан хамгаалалтыг үзүүлэх шаардлагатай байгаа тул “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-аас улаан буудайг даатгах ажлыг 2016 оноос туршилтын журмаар эхлүүлээд байна.

Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүний судалгаа

Олон улсад газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүнийг уламжлалт даатгал болон индексжүүлсэн даатгал гэж ерөнхийд нь 2 ангилдаг байна.

Хүснэгт 13. Тариалангийн даатгалын бүтээгдэхүүний ангилал

	Даатгалын төрөл	Суурилж буй үзүүлэлтүүд	Хэрэгжиж буй даатгалын бүтээгдэхүүнүүд
Уламжлалт даатгал	- Бүх төрлийн эрсдэлт даатгал - Олон эрсдэлт даатгал - Нэрлэсэн эрсдэлт даатгал	Бодит түүхэн мэдээлэлд үндэслэнэ	-Бүх аж ахуйн орлогын даатгал (NISA) -Түүхий эдийн нийт орлогын даатгал (CGRI) -Ургацын алдагдлын даатгал
Индексжүүлсэн даатгал	-Тодорхой итгэлцүүрт суурилсан даатгал	-Бүс нутгийн индексжүүлсэн даатгал -Цаг уурын индексжүүлсэн даатгал	-Бүлгийн эрсдэлийн даатгал (GRP) -Бүлгийн эрсдэлийн орлогын хамгаалалт (GRIP) -Хур тунадаст суурилсан индексжүүлсэн даатгал (PBII)
Гамшгийн даатгал		Бодит түүхэн мэдээлэлд үндэслэнэ	Гамшгийн хамгаалалтын түвшин (CAT)

Уламжлалт даатгал нь бодит хохиролд суурилж нөхөн төлбөрөө олгодог бол индексжүүлсэн даатгал нь тодорхой үзүүлэлтэд суурилж нөхөн төлбөрөө олгодог онцлогтой.

Хүснэгт 14. Уламжлалт даатгал ба индексжүүлсэн даатгал

Онцлог	Уламжлалт даатгал	Индексжүүлсэн даатгал
---------------	--------------------------	------------------------------

Шаардлагатай статистик мэдээлэл	Бодит ургацын мэдээллийг аль болох газарзүйн өндөр нарийвчлалаар гаргана (Сумын нарийвчлалаар гаргах боломжтой).	Бодит ургацын мэдээллийг дундаж нарийвчлалаар (Сумын нарийвчлал) эсвэл ургацын мэдээлэл юм уу цаг агаарын мэдээлэл ашиглан загварчилж гаргана (температур, хур тунадас).
Хамаарах эрсдэлүүд	Хүний үйлдлээс гаралтай эрсдэлийг оролцуулаад тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчийн дэвшүүлсэн бүх эрсдэлийг хамруулна.	Ургацын индексэд суурилсан даатгалын тохиолдолд ургацад хүнд хохирол учруулсан байгалийн бүх эрсдэлийг, цаг агаарын индексэд суурилсан даатгалын тохиолдолд системт байгалийн эрсдэлийг хамруулна.
Даатгалын нийт үнэлгээг тодорхойлох	Улаан буудайн бүтээгдэхүүний хүлээгдэж буй орлого юм уу өсөж буй зардалд суурилна.	Уламжлалт даатгалтай ижил сонголтоор эсвэл нэг га талбайн зохиомлоор дэвшүүлсэн үнэд суурилна.
Даатгалын хувь	Ургацын хэлбэлзлийн түүхэн мэдээлэлд суурилсан тооцно.	Ургацын хэлбэлзлийн түүхэн мэдээлэлд суурилсан тооцох юм уу (ургацын индексэд суурилсан даатгалд) цаг агаарын түүхэн мэдээлэл, цуглуулсан индексэд суурилсан тооцно (цаг агаарын индексэд суурилсан даатгалд).
Хохирол үнэлгээ	Талбай дээр хийж гүйцэтгэнэ.	Тухайн жилийн цаг агаарын эсвэл ургацын мэдээлэлд суурилсан оффист хийж гүйцэтгэнэ.
Нөхөн төлбөр	Улаан буудайг хураан авч ургацын эцсийн хорогдлыг тооцсоны дараа олгоно.	Ургацын мэдээллийг Хүнс, Хөдөө аж ахуйн яамнаас, эсвэл цаг агаарын мэдээллийг Цаг уурын албанаас хүлээн авсаны дараа олгоно(хугацаа хойшлогдож болно)
Талбай дахь бодит хохирлын уялдаа	Өндөр уялдаатай. Талбайд учирсан бодит хохирлын дагуу нөхөн төлбөрийг олгоно.	Бага уялдаатай.Ургацын индексэд суурилсан даатгал нь хүний үйлдсэн эрсдэл болон тухайн газрын эрсдэлийг “хамруулдаггүй”. Цаг агаарын индексэд суурилсан даатгал нь жижиг эрсдэлийг “хамруулдаггүй” ба заримдаа хохирол учраагүй тохиолдолд нөхөн олговор олгодог.
Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн ойлголт	Эерэг. Бүх асуудал талбай дээр буюу тариалангийн үйлдвэр эрхлэгчтэй харилцсаны үндсэн дээр шийдвэрлэгддэг.	Нөхөн олговрын тооцооллыг ойлгодоггүй, анхаарал бага хандуулдаг.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК болон хөдөө аж ахуйн эрсдэлийн менежментийн олон улсын шинжээч Олена Сосенкотой хамтран 2015 оны 10-р сараас 2016 оны 04-р сар хүртэл холбогдох судалгааг хийж, даатгалын бүтээгдэхүүний загварыг боловсруулсан. Даатгалын бүтээгдэхүүний судалгааг хийх явцад улаан буудайг даатгалын бүтээгдэхүүнээр сонгосны дараа уламжлалт даатгал, индексжүүлсэн даатгалын төрлийн аль нэгийг нь сонгох хэрэгтэй болсон. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь малын хорогдлын индексэд суурилсан малын даатгалыг хэрэгжүүлж байгаа ба энэ тал дээр туршлагатай тул ургацын даатгалыг ижил төрлөөр явуулах саналтай байсан. Гэсэн хэдий ч олон улсын зөвлөх үндсэн эрсдэлийг авч үзэхгүй, талбайн ургацын бодит хохирлыг арай илүү ойролцоо байдлаар

тооцдог уламжлалт даатгалын төрлийг ашиглаж үзэхийг зөвлөсөн. Олон улсын туршлагаас үзэхэд (Дэлхийн банкны олон удаагийн төслүүд) уламжлалт даатгал зарим шалтгааны улмаас тохиромжгүй байх тохиолдолд л индексжүүлсэн даатгалыг ашиглахыг зөвлөдөг байна.

Иймд эхлээд уламжлалт даатгалыг хэрэгжүүлээд туршилтын үр дүн хангалтгүй байвал индексжүүлсэн даатгал нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

2016 онд хэрэгжүүлсэн Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын бүтээгдэхүүн

Туршилтын журмаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Ерөө, Зүүнбүрэн, Баруунбүрэн, Цагааннуур, Түшиг, Хүдэр, Хушаат сумдууд болон Төв аймгийн Цээл сумдын тариалан эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдэд улаан буудайн даатгалын бүтээгдэхүүнийг санал болгосон. Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК болон сонг Мөн андеррайтингийн гарын авлага, хохирол үнэлгээний гарын авлагыг боловсруулж, сонгогдсон даатгалын компани /Ард, Бодь, Мандал женерал, МИГ даатгал ХХК/-ийн холбогдох мэргэжилтнүүдийг чадавхижуулсан.

Туршилтын үр дүнд Сэлэнгэ аймгийн Хушаат сумын аж ахуйн нэгжийн 250 га газрыг Бодь даатгал ХХК даатгаж, 13 сая төгрөгийн даатгалын хураамжинд төвлөрүүлж, 2,9 сая төгрөгийг давхар даатгалын хураамж болгон авсан.

Туршилтын үр дүнгээс харахад даатгуулагч хангалтгүй хамрагдсан бөгөөд оролцогч талуудад дараах хүндрэл бэрхшээлүүд гарсан. Үүнд:

- Даатгалын компаниуд тариан талбай дээр очиж газар дээрх хяналт шалгалт хийх, хохирлыг үнэлэх зорилгоор 4-5 удаа очиж байгаа тул үйл ажиллагааны зардал маш өндөр байна.
- Хохирол үнэлгээг хийхэд цаг хугацаа, мэргэжлийн боловсон хүчин шаардлагатай байсан.
- Улаан буудайн даатгалын хувьд өндөр эрсдэлтэй, даатгалын хураамжийн хувь өндөр байгаа тул тариаланчдад даатгалын хураамжийг шууд төлөх бэлэн мөнгө байхгүй байна.
- Ихэнхи тариаланчид банкны зээлтэй төдийгүй төрийн дэмжлэгийг харсаар байна.

Иймд 2017 онд дараах үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.


- Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүнийг илүү боловсронгуй, зардал багатай Индексжүүлсэн даатгалыг нэвтрүүлэх
- Тариаланчдын даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэх
- Газар тариалангийн даатгалын эрх зүйн орчинг бүрдүүлэх /бие даасан хуультай болох/

2017 онд туршилтаар хэрэгжүүлэх газар тариалангийн индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүн

SCOR олон улсын давхар даатгалын компанитай хамтран ажиллах гэрээ байгуулж, тус компаниас индексжүүлсэн даатгалын талаар техникийн зөвлөмж, туслалцаа авч Монгол улсад тогтвортой хэрэгжих боломжтой газар тариалангийн индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнийг 2017 онд туршилтын журмаар хэрэгжүүлнэ.

Тус бүтээгдэхүүний статистик мэдээллийг хиймэл дагуул ашиглан гаргах бөгөөд бүтээгдэхүүн хөгжүүлэх үйл явцыг харуулбал дараах байдалтай байна.

Зураг 1. Тариалангийн индексжүүлсэн даатгал бүтээгдэхүүн хөгжүүлэх үйл явц



2017 оны 4-5 дугаар саруудад индексжүүлсэн даатгалыг туршилтын аймаг сумдуудын тариаланчдад санал болгож, сонгогдсон даатгалын компаниуд борлуулалтыг хийнэ.

Газар тариалангийн индексжүүлсэн даатгалын даатгуулагчаас авах даатгалын нийт хураамжийн орлогыг 43,2 сая, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-д **41 сая төгрөгийн** давхар даатгалын хураамж төвлөрүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 15. Индексжүүлсэн даатгалын төсөөлөл

№	Оролцогч талууд	Зорилт /мянган.га/	Оролцооны хувь	Даатгалын нийт үнэлгээ	Хураамжийн орлого
1	Даатгалын компаниуд	1,200	5%	36,000,000	2,160,000
2	ХААДД ХК		95%	684,000,000	41,040,000
2.1	ХААДД ХК-д үлдэх			108,000,000	6,480,000
2.2	Олон улсын давхар даатгал		80%	576,000,000	34,560,000

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь 2017 онд газар тариалангийн индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнийг хэрэгжүүлж, зөвхөн туршилтаар нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд компани болон дотоодын даатгагчдийг газар тариалангаар туршлага суух хүртэл нийт даатгалын гэрээгээр үүрч буй хариуцлагын хэмжээг 80 хүртэл хувийг давхар даатгуулах бодлого хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Компанийн санхүүгийн чадавхи, зах зээлд оролцогч талуудын мэргэшсэн байдал нэмэгдмэгц компанийн газар тариалангийн даатгалын эрсдэлд орох хувийг бага багаар нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас санаачлан Тариалангийн даатгалын хуулийн үзэл баримтлал болон хуулийн төсөл боловсруулах гэж байгаатай холбогдуулан Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн холбогдох газрын дарга, мэргэжилтнүүд хуулийн ажлын хэсэгт орж ажиллаж байна. Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн зүгээс газар тариалангийн даатгалын талаар олон улсын туршлагыг судлан судалгаа болон эдийн засгийн тооцооллыг эхний байдлаар хийсэн бөгөөд цаашид дээрх судалгаа, тооцооллыг үргэлжлүүлэн хийж, хуулийн үзэл баримтлал, төсөлд өөрийн саналаа өгч ажиллана. Ажлын хэсэг хуулийн төслийг 2017 оны 09-р сард Засгийн газарт хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

3.1.3. Эрчимжсэн мал аж ахуйн даатгал

Манай оронд хамгийн анхны үнээний ферм Дархан хотын ойролцоо 1968 онд байгуулагдсанаас хойш 1990 он гэхэд тус бүр 200-1200 үнээтэй, нийт 19,600 үнээ бүхий нийт 36 сүүний аж ахуй байгуулагдсан байна.

Хот суурин газрын хүн амыг аюулгүй хүнс тэжээлээр хангах хэрэгцээ шаардлагын улмаас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх талаар төр засгаас ихээхэн анхаарч байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд эрчимжсэн фермерийн аж ахуйн тоо нэлээд нэмэгдэж, энэ чиглэлийн бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдсээр байна.

Хүснэгт 16. Фермийн тоо /2006-2014 он/

Он	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2014
Бүгд	284	599	750	980	1035	1294	1662	1713	3138
Сүүний үхрийн ферм	186	395	494	412	523	649	901	977	1554
Махны үхрийн ферм	11	7	10	48	94	101	64	78	351
Мах, ноосны хонины ферм	12	13	15	57	107	128	200	229	236
Сүүний чиглэлийн ямаа	-	-	-	-	-	-	-	-	4
Гахайн ферм	21	72	79	172	135	190	187	181	476
Тахиан ферм	38	81	111	225	105	148	217	152	405
Зөгийн ферм	16	31	40	56	58	68	81	89	299
Туулайн ферм	-	-	1	10	23	10	12	7	30

Үүнээс сүүлийн жилүүдэд махны болон сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн ферм эрчимтэй хөгжиж байна. Сүүний болон махны чиглэлийн үхрийн фермийн тоог доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 17. Сүүний чиглэлийн үхрийн ферм нийт үхрийн тоо

Он	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2014
Фермийн аж ахуйн тоо	395	494	412	523	649	901	977	1554
Үхрийн тоо	8012	10070	12648	19298	21412	27501	32876	59799

Хүснэгт 18. Махны чиглэлийн үхрийн ферм нийт үхрийн тоо:

Он	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2014
Фермерийн аж ахуйн тоо	7	10	48	94	101	64	78	351
Үхрийн тоо	1334	1705	5285	10992	11307	11069	11247	12705

Сүүний болон махны чиглэлийн үхрийн фермийн зах зээлийн багтаамж 362,5 тэрбум төгрөг байгаа бөгөөд цаашид өсөх хандлагатай байна.

Зах зээлийн нийт багтаамж /үхрийн ферм/:

Нийт үхрийн ферм = 59,799 + 12,705 = 72,504

Нийт үнэлгээ = 72,504 * 5,000,000 = 362,520,000,000 төгрөг

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь 2017 онд үхрийн фермийг эхний ээлжинд давхар даатгахар зорьж байгаа бөгөөд үхрийн фермийн үйл ажиллагааг судалсны үндсэн дээр бусад төрлийн фермийг давхар даатгах болно.

Хүснэгт 19. Давхар даатгалын хураамжийн төсөөлөл

Үзүүлэлтүүд	Зорилт
Даатгах үхрийн тоо	600
Даатгалын нэгж үнэлгээ /төгрөг/	5,000,000
Даатгалын нийт үнэлгээ /төгрөг/	3,000,000,000
Даатгалын хураамжийн хувь	1,5%
Даатгуулагчаас авах даатгалын хураамж /төгрөг/	45,000,000
“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн давхар даатгалын хураамж /төгрөг/	36,000,000

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК 2017 онд 500,0 сая хүртэлх төгрөгийн хариуцлагыг өөрт үлдээн давхар даатгах зорилготой ажиллана. Эрчимжүүлсэн үхрийн фермийн нийт давхар даатгалын **хураамжийн орлого 36 сая төгрөг** байхаар төлөвлөж байгаа бөгөөд хувь оролцооны давхар даатгалын гэрээг хийж ажиллана.

4. МАРКЕТИНГИЙН СТРАТЕГИ

4.1. Даатгалын борлуулалтын сувгийн стратеги

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК компани 2017 оны борлуулалтын улиралд аймаг, сумдын удирдлагууд, багийн засаг дарга болон Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамтай хамтын ажиллагааг өргөжүүлэн орон нутагт МИД-ын мэдээлэл, сурталчилгааг хийх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Багийн засаг дарга нь тухайн багийнхаа цаашлаад сумынхаа нийт малчин өрх, хүн амынхаа талаар маш дэлгэрэнгүй мэдээлэлтэй байдаг бөгөөд иргэдэд шууд хүрч ажиллах хамгийн ойрын албан тушаалтан юм. Тиймээс багийн засаг даргаар дамжуулан МИД-ыг идэвхжүүлэх нь илүү үр дүнтэй гэж үзэж байна.


Багийн засаг даргаас сумын МЭҮТ-ийн ажилтанд тайлагнах, сумын МЭҮТ-ийн ажилтнаас аймгийн Хөдөө аж ахуйн газарт тайлагнах, аймгийн Хөдөө аж ахуйн газраас шууд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-д тайлагнах процессыг батлуулах хэрэгтэй.


Засгийн газрын хэрэг эрхлэх газарт “Багийн засаг даргын үр дүнгийн гэрээнд:

1. МИД-ыг малчдад сурталчилан таниулах;
2. Өмнөх оны даатгалд хамрагдсан малчдаас хэдэн хувиар өссөн үзүүлэлтийг үндэслэн дүгнэх;

3. МЭҮТ-ийн ажилтанд МИД-ын талаар ажлаа тайлагнах, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-д мэдээлэх;

гэсэн заалтуудыг оруулж өгнө үү.” гэсэн хүсэлт гаргах.





Мөн ХААХҮЯамтай хамтран ажиллах гэрээ байгуулан хөдөө орон нутагт малын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор дараах чиглэлээр ажиллахаар төлөвлөж байна:

1. Мал хамгаалах сантай хамтран ажиллах боломжийг судлан ноос, ноолуурын болон сүүний урамшуулалд хамрагдсан малчдыг МИД хамруулах нөхцөлийг судлах;
2. Улс, аймаг, сумын сайн малчин болон Мянгат малчин МИД-д даатгагдсан байх гэдэг тодорхойлолтыг "Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК-аас авдаг байх гэх мэт зохицуулалтуудыг хийх хүсэлт тавьж шийдвэрлүүлэх.

4.2. Маркетингийн стратеги, иж бүрдлийн хөтөлбөр

Маркетингийн стратеги төлөвлөгөөний зорилго:

"Хөдөө аж ахуйн давхар даатгал" ХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээг зорилтот зах зээлд таниулах, хүргэх замаар компанийн борлуулалтын орлогын тогтвортой өсөлтийг хангахад маркетингийн стратеги төлөвлөгөөний зорилго оршино.

Маркетингийн стратеги төлөвлөгөөний зорилт:

- Малчдын амьжиргааг зудын эрсдэлээс хамгаалах МИД-ын хамрагдалтыг нэмэгдүүлэх.
- Компанийн зүгээс газар тариалан эрхлэгчдэд санал болгож буй шинэ бүтээгдэхүүнийг сурталчилан таниулж, бүтээгдэхүүний борлуулалтын төлөвлөгөөний биелэлт, тогтвортой өсөлтийг хангах.

- Оновчтой маркетингийн сувгийг ашиглан алслагдсан бүс нутаг, сумдын малчид, тариаланчдад мэдээллийг жигд тархаах, бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх.

Маркетингийн стратеги:

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн маркетингийн стратеги төлөвлөгөөг хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн нөхцөл байдал, мал аж ахуй болон газар тариалангийн судалгаа, шинжилгээнд тулгуурлаж, богино болон урт хугацааны үр дагаврыг тооцсон байдлаар нэгтгэн ашиглана.

Маркетингийн стратеги төлөвлөгөөний хүрээнд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК болон оролцогч талууд болох даатгалын компаниуд, түүний төлөөлөгч, зуучлагч нар, аймаг сумдын удирдлага, малчид, тариаланчдыг оролцуулан маркетингийн зорилго зорилтуудыг хэрэгжүүлэх боломж, нөөц, гарч болох нөхцөл байдал, арга замуудыг тодорхойлно.

Маркетингийн иж бүрдлийн хөтөлбөр:

➤ *Зар сурталчилгаа:*

- Телевиз болон сувгуудын нэвтрүүлгийн дундуур сурталчлах:
 - 2015 оны судалгаанаас харахад телевиз үзэгчдийн тоо буураагүй байгаа юм. Судалгаагаар Монголд 2 сая 500 орчим үзэгчид байгаагаас 1 сая 300 орчим нь буюу нийт үзэгчдийн 50% нь хөдөө орон нутгийн үзэгчид гэдэг нь тогтоогджээ. Одоогийн байдлаар YОНРТ-ийн “Цагийн хүрд”, ТВ9 телевизийн “Монгол коммент”, ТВ5 телевизийн “Цаг” мэдээллийн хөтөлбөр, Малчин телевизийн “Цаг агаарын хөтөлбөр тус тус өндөр рейтингтэй явдаг байна. Иймээс хөдөө орон нутагт хандалт өндөр хэд хэдэн телевизтэй гэрээ хийн хамтран ажиллах нь компанийн үйл ажиллагаа болон бүтээгдэхүүний талаар жигд мэдээлэх сурталчлах боломжтой юм.
 - Борлуулалт 4 сард эхэлдэг учир цагаан сарын дараагаас борлуулалтыг идэвхжүүлэх үүднээс МИД-ын талаар ерөнхий танилцуулга, даатгуулахад малчдын анхаарах зүйлс, нөхөн төлбөр хэрхэн олгогдох, нөхөн төлбөр авсан хүний сэтгэгдэл, өвөлжилтийн байдал болон борлуулалтын хугацааг байнга сануулах байдлаар нэвтрүүлэг бэлдэн тодорхой давтамжтайгаар телевизийн оргил цагаар гаргах.
 - Хандалт ихтэй сувгуудаар бүтээгдэхүүн тус бүрт 30 секундийн богино хэмжээний зар сурталчилгаа байнга цацах. /30 секундийн зар сурталчилгаа, шторк оройн 18.00 цагаас хойш/
 - Малчдад цаг агаарын мэдээ чухал, их үздэг учраас Цаг агаарын мэдээний ард давхар даатгал, тариалан, малын даатгалын талаар лого бэлдэн гаргуулах.
 - Газар тариалангийн даатгалыг индексжүүлсэн болохоор Олон улсын давхар даатгалын SCOR компанитай туршлага солилцон хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа учраас шинэ бүтээгдэхүүний талаар танилцуулах нэвтрүүлэг бэлдэн гаргах.
- *Сонин, тараах материал:*

Малчид, тариаланчдад энгийн үг хэллэгтэй, тодорхой товч мэдээлэлтэй сонин, хэвлэмэл материалыг тараахын тулд:

1. Аймаг сумдын даатгалын төлөөлөгч нараар дамжуулах

2. 21 аймагт тээврийн хэрэгсэл болох автобус үйлчилж байгаа учраас зам тээврийн компаниудтай хамтран ажиллаж тараах материал болон видео

дүрсийг тавих. Одоогийн байдлаар хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг 42 ААНБ 67 чиглэлд 944 тээврийн хэрэгсэл, 1300 жолоочтой тээвэрлэлтийг гүйцэтгэдэг байна. Хот хоорондын зорчигч урсгал 2015 оны эхний хагас жилийн байдлаар нийт 991,2 мянган зорчигч тээвэрлэсэн байна.

3. Давхар даатгал, тариалан, малын даатгалын талаар мэдээлэл бүхий цаг тооны бичиг хэвлүүлж малчид, тариаланчдад тараах.

4. Тариалангийн индексжүүлсэн даатгалын талаар энгийн үг хэллэгтэй товч тодорхой мэдээлэлтэй брошур бэлдэх.

5. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн танилцуулга бүхий тайланг хэвлэн орон нутаг, сумдын засаг дарга, мэргэжилтнүүдэд тараах

– *Радио, FM радиогоор сурталчлах:*

Монголын Үндэсний Радиогоор Малын даатгалын талаар, Газар тариалангийн даатгалын талаар тус тус 20 минутын нэвтрүүлэг бэлтгэн цацах. /МИД-ын танилцуулга, даатгуулахад анхаарах зүйлс, нөхөн төлбөр хэрхэн олгогдох, нөхөн төлбөр авсан хүний сэтгэгдэл, өвөлжилтийн байдал, мөн газар тариалангийн даатгалын танилцуулга мэдээ, тариаланчдын сэтгэгдэл, нөхөн төлбөр хэрхэн олгогдох, цаг уурын мэдээ гэх мэт агуулгатай байж болно/

➤ *Борлуулалтын урамшуулал:*

Шилдэг даатгалын төлөөлөгч сонгон шалгаруулан гадаадын аль нэг улсад амраах эрхийн бичгээр шагнах.

Мөн багийн дарга нарыг идэвхжүүлэх үүднээс нийт Монгол улсын хэмжээнд шилдэг 60 багийн даргыг шалгаруулж шагнах боломжийг судлах.

➤ *Биечилсэн худалдаа:*

Биечилсэн худалдаа хийж байгаа даатгалын төлөөлөгчид, зуучлагч банкны теллерүүдийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж, шууд борлуулалтыг нэмэгдүүлэх.

➤ *Олон нийтийн харилцаа:*

- Аймаг, сум, багийн хэмжээнд зохион байгуулагддаг Засаг дарга нарын уулзалт малчид, тариаланчдын хурал зөвлөгөөнүүдэд орон нутгаас нь болон компанийн зүгээс оролцож, компанийн үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулах, хэрхэн даатгуулах талаар зөвлөгөө өгөхөөс гадна даатгалын компани, төлөөлөгч, зуучлагч нартай холбох
- Аймгийн хэмжээнд малчид тариаланчдад зориулсан томоохон арга хэмжээг тааруулан даатгалын өдөрлөг зохион байгуулах
- Газар тариалангийн даатгалын талаар холбогдох албан тушаалтнууд болон тариаланч нартай уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж сурталчлан таниулах
- 2016 онд шинэ брендбүүк гаргасантай холбоотойгоор нийт даатгалын төлөөлөгч нарт зориулан манай компанийн хавтас дэвтэр зэрэг зүйлсийг хэвлүүлэн тараах

➤ *Шууд маркетинг:*

- Мессеж илгээх:

-“Малчин та малын даатгалдаа идэвхтэй хамрагдана уу.” гэх мэт утгатай мессежийг Мобиком, Юнитель, Скайтел, Жи-мобайлын сүлжээний малчин, тариаланч нарын үүрэн утас руу илгээх

- DDISH- кабелтай хамтран байгууллагын банер байршуулах

➤ **Бусад үйл ажиллагаа:**

- Төрийн банк, ХААН банкнуудтай байгуулдаг даатгалд хамрагдсан малчдын зээлийн хүүг 0,2 хувиар бууруулдаг гэрээг үргэлжлүүлэн, хамрах хүрээг нь өргөжүүлж, тариаланчдад олгодог бизнесийн зээлийн хүүнд хөнгөлөлт үзүүлэх талаар банкуудтай хамтран ажиллах, зөвшилцөх, малчид банкнаас зээл авах бол МИД-д заавал даатгуулсан байх гэдэг нөхцөлийг судлах.

- Аймаг, сумын эрх бүхий албан тушаалтны ажил үүргийн хуваарьт тариалангийн даатгалын асуудлыг хариуцах талаар тусган ажиллах:

- ЗГХЭГ-тай холбогдон, компанийн үйл ажиллагааг орон нутагт хариуцан, борлуулалтыг тодорхой заасан түвшнээс багагүй хэмжээнд барьж ажиллах аймаг сумын эрх бүхий албан тушаалтныг тодорхойлж, ажил үүргийн хуваарьт нь тусгаж өгөх, борлуулалтын үр дүнгээс нь хамаарч урамшуулах, эсхүл хариуцлага тооцдог тогтолцоог бий болгох

➤ **Багийн даргын ажил үүргийн хуваарьт дараах зүйлсийг тусгаж оруулах:**

- МИД-ын талаар мэдээллийг багийнхаа малчдад байнга сурталчлан таниулах.
- Малын хорогдлын мэдээг үнэн зөв гаргаж өгөх.

5. МЕНЕЖМЕНТ

5.1. Компанийн зохион байгуулалт

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь 5 газар нэгжтэй. Үүнд: Андеррайтингийн газар, Бизнес хөгжил, төслийн газар, Экспортын даатгалын газар, Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар, Санхүү удирдлагын газар орно.

Андеррайтингийн газар:

Андеррайтингийн газар нь дараах чиг үүрэгтэй:

1. Компанийн давхар даатгалын үйл ажиллагааг зохион байгуулж, давхар даатгалын гэрээ байгуулан, даатгагч нарын давхар даатгуулах эрсдэлийн үнэлгээг /андеррайтинг/ хийх,
2. МИД-ын бүтээгдэхүүний эрсдэлийн үнэлгээ, давхар даатгалын хураамж болон оролцогчийн хураамжийн тооцооллыг хийх,
3. Орон нутаг дахь даатгалын төлөөлөгчид, мэргэжилтнүүдтэй харилцаж ажиллах,
4. Давхар даатгалын бүтээгдэхүүнтэй холбоотой актуар тооцооллыг хийх,
5. МИД болон бусад давхар даатгалын бүтээгдэхүүний бүртгэл, эрсдэл тооцооллыг програм хангамжийг боловсруулах,
6. Ажилтнуудын компьютерт зайлшгүй шаардлагатай болон хэрэгцээтэй бүртгэлийн, системийн болон хэрэглээний программ хангамжийг суулгаж өгөх, компанийн цахим хуудасны мэдээллийг сүлжээнд оруулж, олон нийтэд хүргэх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, засвар үйлчилгээг хийх,
7. Оролцогч даатгалын компаниуд болон зуучлагч банкиудтай хамтарч ажиллах

Андеррайтингийн газар дараах орон тоотой байна. Үүнд:

- Газрын дарга.
- Андеррайтер 1. МИД-ын бүтээгдэхүүн хариуцан ажиллах бөгөөд хөтөлбөрт оролцогч даатгалын компаниудтай харилцаж ажиллана. Дундын дансыг бүрдүүлэх, зохион байгуулах болон давхар даатгалын хураамж төвлөрүүлэх, эрсдэлийн тооцооллыг хийж гүйцэтгэнэ. Мөн түүнчлэн МИД-тай холбоотой тооцоолол болон дансны гүйлгээг хянаж ажиллана.
- Андеррайтер 2. Газар тариалангийн даатгал хариуцсан ажилтан. Хөтөлбөрт оролцогч компаниудтай газар тариалангийн бүтээгдэхүүн хариуцан ажиллаж, давхар даатгуулах эрсдэлийн үнэлгээ хийнэ.
- Актуарч. Шинэ болон хэрэгжүүлж буй даатгалын даатгалын бүтээгдэхүүний хураамж тооцоолол, хохирол үнэлгээний актуар тооцооллыг хийх
- Даатгалын шинжээч 1. Хөдөө аж ахуйн давхар даатгалын бүтээгдэхүүний судалгаа, шинжилгээ хийж, мэдээлэл боловсруулна. Орон нутаг дахь даатгалын төлөөлөгчид, мэргэжилтнүүдтэй харилцаж ажиллана. Аймаг сумдын удирдлагууд болон холбогдох ажилтнуудтай хамтран ажиллаж, компанийн үйл ажиллагааг хөдөө орон нутагт тогтвортой хэрэгжүүлнэ.
- Даатгалын шинжээч 2. Давхар даатгалын бүтээгдэхүүний судалгаа, шинжилгээг хийж, мэдээлэл боловсруулна. Орон нутаг дахь даатгалын төлөөлөгчид, мэргэжилтнүүдтэй харилцаж ажиллана.
- Мэдээлэл технологийн ажилтан 1. МИД-ын болон бусад давхар даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэх, эрсдэл тооцоог хийх програм хангамжийн асуудлыг хариуцан ажиллана.
- Мэдээлэл технологийн ажилтан 2. Компанийн системийн зохицуулагчийн үүргийг хүлээж бүх компьютер, тоног төхөөрөмж, дотоод болон гадаад сүлжээг хэвийн ажиллагаатай байлгана. Компанийн цахим хуудасны мэдээллийг сүлжээнд оруулна.
- **Агрономич 1. Компанийн газар тариалангийн даатгалтай холбоотой асуудлыг хариуцан ажиллана. Үүнд: газар тариалангийн даатгалын андеррайтинг, хохирол үнэлгээг хийх, холбогдох зааврыг боловсруулахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, тариалангийн сургалт хийнэ.**

Бизнес хөгжил, төслийн газар

Бизнес хөгжил, төслийн газар нь дараах чиг үүрэгтэй:

1. Даатгалын шинэ бүтээгдэхүүний загварыг гаргах,
2. Тариалангийн даатгалыг хэрэгжүүлэх
3. Зах зээлийн болон эрсдэлийн судалгаа хийж шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж турших ажлыг хийж хэрэгжүүлэх ,
4. Туршигдсан бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулах, давхар даатгалын бүтээгдэхүүний судалгаа шинжилгээ хийж, мэдээлэл боловсруулах,
5. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, шаардлагатай судалгаа хийх, Төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тооцоолол хийх, батлуулах, зарцуулалтанд хяналт тавих
6. Олон улсын болон дотоодын төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх,
7. Компанийн сургалт сурталчилгаа, гадаад харилцаа болон хамтын ажиллагааг бэхжүүлэх,
8. Компанийн бизнесийн стратеги, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх.

Бизнес хөгжил, төслийн газар дараах орон тоотой байна. Үүнд:

- Газрын дарга.

- Шинэ бүтээгдэхүүн хариуцсан ажилтан. Зах зээлийн болон эрсдэлийн судалгаа хийж шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж турших судалгааны ажлыг хийх.
- Шинэ бүтээгдэхүүн хариуцсан ажилтан. Зах зээлийн болон эрсдэлийн судалгаа хийж шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж турших судалгааны ажлыг хийх.
- Шинэ бүтээгдэхүүн хариуцсан ажилтан. Зах зээлийн болон эрсдэлийн судалгаа хийж шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргаж турших судалгааны ажлыг хийх.
- Төслийн менежер. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, шаардлагатай судалгаа хийх Төслийн танилцуулга, бичиг баримт боловсруулах, гүйцэтгэл, нөхцөл байдалд шинжилгээ хийх, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих, хөрөнгө оруулалтын шинжилгээ хийнэ.
- Эрсдэлийн шинжээч. Компанийн үйл ажиллагааны эрсдэл, даатгалын гэрээний эрсдэл, давхар даатгалын эрсдэл, санхүүгийн, хүний хүчин зүйлийн, улс төрийн хууль эрх зүйн, зах зээлийн эрсдэлийн шинжилгээ хийнэ.
- Эрсдэлийн шинжээч. Компанийн үйл ажиллагааны эрсдэл, даатгалын гэрээний эрсдэл, давхар даатгалын эрсдэл, санхүүгийн, хүний хүчин зүйлийн, хууль эрх зүйн, улс төрийн, зах зээлийн гэх мэт эрсдэлийн шинжилгээ хийнэ.
- Гадаад хамтын ажиллагааны ажилтан. Олон улсын болон төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Компанийн гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлнэ.
- Маркетингийн менежер. Компанийг болон давхар даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд сурталчлан таниулах, холбогдох сургалт семинар зохион байгуулах зэрэг ажлыг зохион явуулна.

Экспортын даатгалын газар

Монгол Улсын уул уурхайгаас бусад салбарын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн экспортын чадавхийг бэхжүүлж, гадаад зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацитай хамтран “Экспортыг дэмжих төсөл”-ийг хэрэгжүүлж байна. “Экспортыг дэмжих төсөл”-ийг хэрэгжүүлснээр Монгол Улсын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тэдэнд гадаад зах зээлд экспортлоход шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох, гадны улс орнуудаас туршлага судлах, экспортын даатгал гэх мэт санхүүгийн шинэ бүтээгдэхүүнийг зэх зээлд бий болгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна тодорхой зорилтот зах зээлүүдэд нэвтрэх боломжийг нээх юм.

Уг төслийн хүрээнд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Экспортын даатгалын газар нь экспортод чиглэсэн үндэсний аж ахуйн нэгжүүдэд экспортын зээлийн даатгал олгох ажлыг хариуцан ажиллаж байна.

Экспортын даатгалын газар нь дараах чиг үүрэгтэй:

1. Экспортын даатгалын зах зээл дэх жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид буюу даатгуулагчдад чиглэсэн дэлгэрэнгүй судалгааг боловсруулах
2. Экспортын зах зээлд тулгарч буй үндсэн эрсдэлүүдэд дэлгэрэнгүй шинжилгээ хийх
3. Даатгуулагчдын шаардлага, хэрэгцээнд нийцсэн экспортын зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулах
4. Бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд шаардлагатай андеррайтингийн журам, эрсдэлийн удирдлагын зарчим, үнэлгээний аргачлал, актуар тооцоолол; нөхөн төлбөрийг олгох явц, даатгалын өргөдлийн маягт, загварууд; даатгалтай холбоотой бусад баримт бичгийг боловсруулах

5. Шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэх үүднээс олон улсын нэр хүнд бүхий байгууллага, зөвлөх, мэргэжилтэний сургалтад хамрагдаж туршлага, ур чадвар эзэмших
6. Олон улсын болон төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх

Экспортын даатгалын газар дараах орон тоотой байна. Үүнд:

- Газрын дарга: гэрээ, хэлэлцээр, батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу төслийн хэрэгжилтийг хангуулах, хэрэгжилтийн үр дүнг хариуцах, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх
- Зохицуулагч мэргэжилтэн: Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн ажлын үр дүнг хариуцах, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг дүрэм, журамд заасан зарчмын дагуу хэрэгжүүлэх

Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар

Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар нь дараах чиг үүрэгтэй:

1. Компанийн дүрмийн сангийн хөрөнгийг холбогдох зохицуулалтын хүрээнд удирдах
2. Эрсдэлийн сангууд болох алдагдлаас хамгаалах сан, хамтын эрсдэлийн сан, дээд болон дунд түвшний эрсдэлийн сангуудыг бүрдүүлэх, удирдан зохион байгуулах
3. Компанийн хөрөнгө оруулалтын орлогыг бүрдүүлэх, шийдвэрлэх
4. Нөхөн төлбөрийн тооцоолол хийх, даатгуулагчдад нөхөн төлбөр олгох асуудлыг хариуцах
5. Хөрөнгө оруулалтын сувгийн судалгаа хийх

Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар дараах орон тоотой байна. Үүнд:

- Газрын дарга.
- Хөрөнгө оруулалтын шинжээч. Компанийн нөөц сангууд болох алдагдлаас хамгаалах сан, дээд болон дунд түвшний эрсдэлийн сангуудын зохион байгуулалтыг хийнэ.
- Нөхөн төлбөрийн менежер. Давхар даатгалын гэрээний хүрээнд гарсан нөхөн төлбөрийн тооцооллыг хийх, давхар даатгуулагчид олгох ажлыг хариуцна. Хамтын эрсдэлийн сангийн зохион байгуулалтыг хийнэ.
- Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ажилтан. Хөрөнгө оруулалт хийх сувгуудыг судлан компанийн хөрөнгө оруулалтын орлогыг нэмэгдүүлнэ. Компанийн дүрмийн сангийн зохион байгуулалтыг хийнэ.

Санхүү, удирдлагын газар

Санхүү, удирдлагын газар нь дараах чиг үүрэгтэй:

1. Хүний нөөцийн бодлого, ажилчдын эрүүл мэнд, нийгмийн асуудал, хөдөлмөрийн гэрээтэй холбоотой аливаа асуудлыг хариуцан зохион байгуулах
2. Компанийн жилийн санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулах, батлуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах
3. Компанийн худалдан авалтын үйл ажиллагаа, ажлын байр, техник хэрэгсэл, эд зүйлийн хангамж, бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг хариуцан зохион байгуулах

4. Компанийн үйл ажиллагааны тайлан гаргах, нэгтгэх,
5. Компанийн дотоод нэгжийн үйл ажиллагааг уялдуулах, бичиг хэргийн хөтлөлт, удирдлагад туслах ажил үүргийг гүйцэтгэх

Санхүү, удирдлагын газар дараах орон тоотой байна. Үүнд:

- Газрын дарга.
- Нягтлан бодогч. Компанийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн явуулна. Удирдлагыг санхүүгийн мэдээллээр хангах, тайлан бэлтгэнэ.
- Захиргаа, хүний нөөцийн ажилтан. Компанийн дотоод нэгжийн үйл ажиллагааг уялдуулах, бичиг хэргийн ажилтан, удирдлагын туслахын үүргийг гүйцэтгэнэ. Компанийн худалдан авалтын үйл ажиллагааг хариуцан ажиллана.
- **Туслах нягтлан бодогч. Санхүүгийн гүйлгээг бүртгэх, баримт бүрдүүлэх, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг хариуцна.**
- Жолооч 1. Хариуцсан машин техникээ чадварлаг эзэмшиж, техникийн бэлэн байдлыг бүрэн ханган, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд үйлчилнэ.
- Жолооч 2. Хариуцсан машин техникээ чадварлаг эзэмшиж, техникийн бэлэн байдлыг бүрэн ханган, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд үйлчилнэ.

5.2. Удирдлагын багийн бүрэлдэхүүн, тэдний үүрэг хариуцлага

Гүйцэтгэх захирал:

Компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

- Компанийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, зохицуулах, хянах замаар компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж ажиллана.
- Компанийн зорилт, стратеги, бодлого, хөтөлбөрийг тодорхойлох, ерөнхий удирдлага, чиглэлээр хангана.
- Компанийн төсөв боловсруулах, батлуулах, удирдах, зардлыг хянах, хүний нөөцийн болон санхүүгийн нөөцийн үр ашигтай зарцуулалтыг хангах.
- Компанийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянах, үнэлэх, зөвлөмж, тайланг судлах, гадна талд байгууллагаа төлөөлөх

Орлогч захирал:

Компанийн тодорхой чиг үүргийг удирдан зохион байгуулна.

- Компанийн зорилт, стратеги, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах
- Гүйцэтгэх захирлын эзгүйд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар ханган ажиллах
- Давхар даатгалын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах
- Сургалт сурталчилгааны ажлыг хариуцах

Хуульч:

Компанийн ажилтнуудыг хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, хууль тогтоомж, дүрэм, журмын төсөл боловсруулах, шийдвэр албан бичгийн төслийг хянах, компанийг хууль хяналтын байгууллагад төлөөлөх зэргээр компанийн үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлийг хангах чиглэлээр дараах ажлыг гүйцэтгэнэ.

- Даатгал /давхар/-ын зах зээлийн зохицуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр санал өгөх,
- Компанийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, нэмэлт, өөрчлөлтийн төсөл

- боловсруулах, шинэчлэх, шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих,
- Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын шийдвэрийн төслийн эрх зүйн үндэслэлийг хянах, зөвтгүүлэх, боловсруулах,
- Компанийн бусад этгээдтэй байгуулах гэрээ, хэлцэл, санамж бичгийн төсөл боловсруулах, эрх зүйн үндэслэлийг хянах, зөвтгүүлэх, хууль тогтоомжид нийцүүлэх,
- Бүх албан бичгийн төслийг хянах, боловсруулах, зөвтгүүлэх, компанийн хэмжээнд эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлыг эрхлэн гүйцэтгэх,
- Компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа хэрэг маргаантай асуудлаар хуулийн байгууллагад төлөөлөх,
- Компанийн нэр бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд бүртгэх, хянах, хадгалах, АТГ-т тайлагнах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэхтэй холбоотой ажлыг зохион байгуулах,

Андеррайтингийн газрын дарга:

Давхар даатгалын эрсдэлийн үнэлгээ хийж, туршигдсан бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулна.

- Андеррайтингийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.
- Компанийн давхар даатгалын үйл ажиллагааг зохион байгуулж, даатгагч нарын давхар даатгуулах эрсдэлийн үнэлгээг /андеррайтинг/ хийх.
- Туршигдсан бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулах.
- ОУДД-ын байгууллагуудтай хамтран ажиллах ажлыг зохион байгуулах.

Бизнес хөгжил, төслийн газрын дарга:

Зах зээлийн судалгаа хийж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаж турших, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, шаардлагатай судалгаа хийх, сургалт зохион байгуулах, сурталчлан таниулах зэрэг ажлыг удирдан зохион байгуулна.

- Бизнес хөгжил, төслийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.
- Зах зээлийн судалгаа хийж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргаж турших ажлыг зохион байгуулах.
- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, шаардлагатай судалгаа хийх, сургалт зохион байгуулах, сурталчлан таниулах зэрэг ажлыг удирдан зохион байгуулах.
- Компанийн бизнесийн стратеги, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.

Экспортын даатгалын газрын дарга:

Экспортын даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, хөгжүүлэхтэй холбоотойгоор шаардлагатай судалгаа шинжилгээ хийх, сургалт зохион байгуулах, ажилтнуудын ур чадварыг сайжруулах зэрэг ажлыг удирдан зохион байгуулна

- Экспортын даатгалын газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.
- Шаардлагатай судалгаа, шинжилгээг хийж гүйцэтгэх.
- Сургалт зохион байгуулах, сурталчлан таниулах, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, экспортын даатгалын чиглэлээр мэргэшүүлэх зэрэг ажлыг удирдан зохион байгуулах.
- Гэрээ, хэлэлцээр, батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу төслийн хэрэгжилтийг хангуулан, хэрэгжилтийн үр дүнг хариуцаж, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх.

Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын дарга:

Компанийн хөрөнгө оруулалтын орлогыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

- Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.
- Компанийн сангийн хөрөнгийг холбогдох зохицуулалтын хүрээнд удирдах.
- Компанийн хөрөнгө оруулалтын орлогыг бүрдүүлж, нөхөн төлбөр тооцоолох, олгох ажиллагааг удирдан зохион байгуулах.

Санхүү, удирдлагын газрын дарга:

Компанийн тайлан бэлтгэх, нэгтгэх, хүний нөөц, худалдан авалтын асуудлыг хариуцах замаар компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явагдах нөхцлийг ханган ажиллана.

- Санхүү, удирдлагын газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.
- Хүний нөөцийн бодлого, ажилтнуудын эрүүл мэнд, нийгмийн асуудал, хөдөлмөрийн гэрээтэй холбоотой аливаа асуудлыг хариуцах.
- Компанийн ажлын байр, техник хэрэгсэл, эд зүйлийн хангамж, бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг хариуцан ажиллах.
- Санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдах, хяналт тавих, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргах, нэгтгэх, тайлагнах ажлыг хариуцах.

Дотоод хяналтын ажилтан:

Компанийн төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм журам, стандарт гэрээг мөрдөж байгаа байдалд болон хөрөнгө, өр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт зэрэгт дотоод аудит хийнэ.

- Компанийн төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдалд дотоод аудит хийх,
- Хөрөнгө, орлого, зарлага, өр, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт зэрэгт дотоод аудитыг явуулах,
- Компанийн онцлогийг тусгасан дотоод аудиттай холбоотой журам, заавар, гарын авлага боловсруулж, батлуулах.

6. САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 20. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн 2017 оны санхүүгийн төлөвлөгөө

ҮЗҮҮЛЭЛТ	МӨР	ТӨЛӨВЛӨГӨӨ
I.ОРЛОГЫН ДҮН	1=2+3+4+5	6,687,646.93
Төсвөөс урсгал санхүүжилт	2	-
Нийт орлогод тооцсон хураамж (дээд, дунд түвшин)	3	1,280,927.00
Бондын өгөөж	4	2,406,167.82
Бусад орлого (хүүгийн орлого)	5	3,000,552.11
II.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	6=7	2,605,446.81
A.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	7=8+36	2,605,446.81
1.Бараа үйлчилгээний зардал	8=9+13+19	1,911,000.81
1.1.Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	9=10+11+12	1,024,883.20
Үндсэн цалин	10	897,912.00
Унаа, хоолны хөнгөлөлт	11	37,180.00

Нэмэгдэл, урамшил	12	89,791.20
1.2.Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл	13=(14+...+18)	112,737.15
Тэтгэврийн даатгал	14	71,741.82
Тэтгэмжийн даатгал	15	8,199.07
ҮОМШӨвчний даатгал	16	10,248.83
Ажилгүйдлийн даатгал	17	2,049.77
Байгууллага төлөх ЭМД-ын хураамж	18	20,497.66
1.3.Бараа үйлчилгээний бусад зардал	19=(20+...+35)	773,380.46
Бичиг хэрэг	20	3,060.00
Тээвэр (Шатахуун)	21	15,626.16
Шуудан, холбоо	22	15,120.00
Дотоод албан томилолт	23	102,000.00
Гадаад албан томилолт /арга хэмжээ/	24	36,000.00
Ном хэвлэл авах	25	1,478.40
Элэгдлийн зардал	26	70,000.00
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл /БҮТЭЗ/	27	7,008.00
Урсгал засвар	28	9,540.00
Төлбөр хураамж, бусад төлбөр	29	84,093.90
Хөрөнгө оруулалтын зардал	30	12,390.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	31	190,000.00
Банк санхүүгийн байгууллагын хураамж	32	300.00
Байрны түрээсийн төлбөр	33	142,314.00
Мэдээлэл сургалт, сурталчилгааны зардал	34	139,450.00
Гадаад зочин төлөөлөгчийн зардал	35	15,000.00
2.Татаас ба урсгал шилжүүлэг	36=37+...+40	694,446.00
Даатгалын төлөөлөгчдөд олгох урамшуулал	37	30,000.00
Мэргэжилтнийг ажиллуулах хөлс	38	9,000.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	39	27,200.00
Гадаад шилжүүлэг /ОУДД-ын хураамж (retrosession)/	40	628,246.00
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	41=1-6	4,082,200.12
Орлогын албан татварын зардал	42=5*10%	300,055.21
Татварын дараах ашиг /алдагдал/	43	3,782,144.91
АЖИЛЛАГСАД БҮГД	44=(45+...+48)	41
ТУЗ-ийн гишүүн	45	9
Удирдах ажилтан	46	6

Гүйцэтгэх ажилтан	47	24
Үйлчлэх ажилтан	48	2

Хүснэгт 21. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн 2017 оны худалдан авах ерөнхий төлөвлөгөө

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөвт өртөг (мян.төг)	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам
1	Оффисын байр түрээслэх	142,314.00	Нээлттэй тендер шалгаруулалт
2	Өөрийн эрсдэл ба төлбөрийн чадварын үнэлгээ хийлгэх	90,000.00	Хосолмол үнэлгээний арга
3	Аудитын үйлчилгээ	100,000.00	Хосолмол үнэлгээний арга
4	Тавилга, эд хогшил, техник хэрэгсэл худалдан авах	7,390.00	Шууд худалдан авалт
5	Компьютер, техник хэрэгсэл худалдан авах	5,000.00	Шууд худалдан авалт
НИЙТ ДҮН		344,704.00	

7. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

7.1. Эдийн засаг, улс төрийн эрсдэл

Монгол Улсын эдийн засагт цэвэр дүнгээр орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) 2011-2012 онд нийлбэр дүнгээр 9.0 тэрбум ам.долларт хүрч, нэг жилд ногдох ГШХО-ын дундаж хэмжээ нь мөн хугацаанд ДНБ-ий 40 гаруй хувийг эзэлж байсан бол 2016 онд ГШХО ердөө 276 сая ам.доллар болж ДНБ-ий 2 хувьтай тэнцэх түвшин рүү огцом буурчээ. Хятадын эдийн засгийн өсөлт үргэлжлэн удааширч, уул уурхайн түүхий эдийн гадаад эрэлт бууран, хөрөнгийн урсгал хөгжингүй орнуудыг чиглэж, Хятад улс болон хөгжингүй орнуудаас хөгжиж буй орнуудад хийх хөрөнгө оруулалтын хэмжээ буурах сөрөг хандлага 2016 онд ч үргэлжиллээ. АНУ-ын Төв банкнаас хэрэгжүүлж буй бодлогын нөлөөгөөр ам.долларын ханш дэлхийн бусад валютын эсрэг чангарсан болон манай улс руу чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт, ашигт малтмалын түүхийн эдийн үнийн уналт зэрэг хүчин зүйл нь үндэсний валютын ханш болон гадаад валютын нөөцөд нэмэлт ачаалал, сөрөг нөлөөллүүд бий болгосоор байна. Хэдийгээр дотоодын эдийн засаг болон санхүүгийн салбарын нөхцөл байдал хүндэрсэн ч 2016 оны сүүлийн хагаст дэлхийн зах зээлд Монгол Улсын экспортын голлох бүтээгдэхүүн болох нүүрс, зэс, алт, төмрийн хүдэр, цайр зэрэг ашигт малтмалын үнэ өсөх хандлага ирэх жилүүдэд ажиглагдаж байна.

Улс төр, эдийн засгийн орчин муудах, түүний тодорхойгүй байдал, институцийн чадавх зэрэг нь бизнес, санхүүгийн байгууллагуудад хүчтэй нөлөөлдөг төдийгүй компанийн бүтээгдэхүүн хэрэглэгч буюу малчдын амьжиргааны түвшинд сөрөг үр дагавар үзүүлж, бүтээгдэхүүн борлуулах үйл явцад эрсдэл бий болдог. Хөдөө аж ахуйн салбар нь монголчуудын уламжлалт салбар бөгөөд ДНБ-ийн 20 орчим хувийг үйлдвэрлэж, хүн амын хүнсний хангамж, үндэсний үйлдвэрийн түүхий эдийн гол тулгуур болж байгаа тул хөгжлийн түвшинг тодорхойлох нэг үндэс суурь юм. Түүнчлэн манай улсад ажиллагсдын 35 орчим хувь

нь тус салбарт ажиллаж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогоор амьжиргааны гол эх үүсвэрээ болгож байгаа нь мал аж ахуй, газар тариалангийн салбараас манай орны эдийн засаг ихээхэн хамааралтайг харуулж байна. Тухайн салбар өсөж хөгжихийн хирээр хөдөө аж ахуйн давхар даатгалын эрэлт нийлүүлэлт ихсэж, өргөжин тэлэх чухал ач холбогдолтой. Тиймээс “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн баримтлах зорилтын хүрээнд хөдөө аж ахуйн салбарын хөгжил, цаашид эдийн засгийн салбарт авчрах өгөөжийг судлан дүгнэлт гаргаж, “Үр ашигтай эрсдэлийн удирдлага”-ыг цогцоор нь хэрэгжүүлэх нь нэн тэргүүний асуудал юм. Компанийн эрсдэлийн бодлогын зорилго нь даатгуулсан даатгуулагч, хамтран ажиллагч байгууллагуудын эрсдэлийг зөв зохистой удирдах, компанийн төлбөрийн чадвар, нөөцийн санг зохистой хэмжээнд тооцоолж, өөрийн байр суурийг нэмэгдүүлж, даатгалын эрсдэлийг боломжит доод хэмжээнд барьж, үр ашигтай хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэж байна.

Хөдөө аж ахуйн даатгалын эрсдэлийн ангилал

1. Малчдаас үүсэх эрсдэл
2. Төр засгийн шийдвэрээс үүсэх эрсдэл

Малчдаас үүсэх эрсдэл

Хөдөө аж ахуйн давхар даатгалын эрсдэл нэн тэргүүнд малчин иргэдээс хамааралтай байдаг тул гадаад, дотоод орчны эрсдэлийг тодорхойлохоос өмнө малчин өрхүүдээс үүсч болох эрсдэлийг шинжлэх нь зүйтэй.

Малчин өрхийн амьжиргааны түвшин, орлогоос хамааран малчид малаа даатгуулах боломжгүй байдаг. Байгаль цаг уурын болон зах зээлийн орчны таатай бус өөрчлөлтийн улмаас малчдын амьжиргааны түвшин тогтвортой бус байнга өөрчлөгдөж байна. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх үр ашигтай суваг бүрдээгүй нь малчдын амьжиргааг бүрдүүлэхэд бодит саад бэрхшээл учруулж байна. Улс орон бүр эдийн засгийн өсөлт, хүний хөгжил, байгалийн нөөц, баялгийн ашиглалт гурвын хоорондын оновчтой шүтэлцээ уялдааг хангахгүйгээр ямар ч салбар ирээдүйд тогтвортой хөгжих боломжгүй болохыг хүлээн зөвшөөрөөд байна. Мал аж ахуйн хөгжил нь хоорондоо нягт шүтэлцээ бүхий малчин-мал-бэлчээр-капитал-менежмент гэсэн үндсэн 5 хүчин зүйлээр тодорхойлогдоно. Мал ахуйн салбар, тэнд ажиллагсдын хөдөлмөр, нийгмийн асуудлыг сайжруулах бодлогыг малчин өрх бүрт хүргэхийн тулд малчин өрхүүдийн аж ахуйн эдийн засгийн ашиг тус, зах зээлтэй холбогдож буй байдлыг судалж үнэлэлт өгөх, сайжруулах боломж арга замыг тодорхойлох шаардлагатай байна.

Малчин өрхийн амьжиргааны түвшин нь дараах нөхцөлүүдээс хамааран харилцан адилгүй байна. Үүнд:

- Малчин өрхүүд нь өргөн уудам нутагт тархан суурьшдаг бөгөөд цаг уурын болон бэлчээрийн мал маллах янз бүрийн нөхцөлд байдаг.
- Төв суурин газраас алслагдах зайнаас хамааран өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнэ харилцан адилгүй борлуулалттай. Орлогын нөгөө тал болох малчин өрхийн зарлагыг судлан үзвэл хүнсний хэрэглээ болон ахуйн хэрэглээний бараа, эрүүл мэнд, боловсрол соёлын зардлууд болон иргэний үүргийн биелэлт бүхий зарцуулалтыг хийдэг.

- Малын тоо, төрөл нь малчин өрх бүрт харилцан адилгүй байгаагаас хамааран орлогын хэмжээ өөр өөр байдаг. Малын тоо нь тогтвортой орлоготой байлгах амьжиргааны эх үүсвэр ба байгаль цаг уурын нөлөөнөөс ихээхэн хамаардаг эрсдэлтэй.
- Малчин өрхийн орлогын нэг чухал эх үүсвэр бол малаа борлуулсны орлого, мөн малаас авч буй ашиг шим болох бүтээгдэхүүн борлуулалтын /мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, түүхий эд.. г.м/ орлого. Үүнээс гадна бусдын мал маллаж нэмэлт орлого олох, гарын ур дүйтэй малчин иргэд гэр ахуйн болон малын тоног хэрэгсэл хийж худалдаалах, байгалийн хишиг олборлон борлуулах зэрэг орлогын бусад төрлүүд байх авч ихэнх малчин өрхүүд мал аж ахуйгаа дагнан амьжиргаагаа залгуулж байна.

Малчдын мэдлэг боловсрол

Мал аж ахуйн салбарын бүтээмжид нөлөөлж буй хүчин зүйлсийг мэдлэг, боловсрол, туршлага, технологи, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа гэсэн чиглэлээр тодорхойлж болно. Малчид мал аж ахуйн арвин туршлагатай боловч технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын тогтолцоо, хамтран ажиллах арга хэлбэрээ олоогүй, мэдээллээс хоцрогдмол, бүтээгдэхүүнээ зах зээлд үр ашигтай худалдахад сайтар суралцаагүй зэрэг дутагдал ажиглагдаж байна. Хөгжил дэвшлийн шийдвэрлэх хүчин зүйл нь хүн өөрөө юм. Тиймээс мал аж ахуйн салбарын хөгжлийг малчин хүнд хөрөнгө оруулж хөгжүүлэхгүйгээр дэвшил гарахгүй. Иймээс үндэсний хэмжээнд малчдын мэдлэг боловсролд анхаарч ажиллах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжин хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах, мэдээллээр бүрэн хангах нөхцөл бололцоог бүрдүүлэхийн сацуу цаг тухайд нь малчдад хүргэхэд анхаарах шаардлагатай. Иймд, байгууллагын зүгээс үйл ажиллагаа ижил төстэй төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран малчин өрх бүрт тэдний амьдрал ахуй, хөдөө аж ахуйн салбартай холбоотой төр засгийн шийдвэрүүдийг танилцуулахын сацуу хөдөө аж ахуйн даатгалын талаар мэдлэг мэдээлэл хүргэж, давуу талуудыг таниулах төлөвлөгөөтэй ажиллана. Засгийн газрын зүгээс мал аж ахуйн мэргэжилтнийг бэлтгэх, давтан сургах, мал аж ахуйн хөгжлийн талаарх олон улсын туршлагыг судлах, нэвтрүүлэх, “Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах” хөтөлбөр хэрэгжүүлэхээр зорьж байна. Тогтвортой, хариуцлагатай, эрх зүйт төрийг төлөвшүүлэхийн тулд хөдөөгийн иргэдийн аюулгүй орчинд амьдрах, малчдыг мэдээллээр хангах хөтөлбөр хэрэгжүүлж, сум, багийнхаа үйл ажиллагаанд орон зайн тэгш бус байдлаас үл хамааран жигд оролцох боломжоор хангахаар бодлого боловсруулсан байгааг компаний зүгээс оролцоотой төлөвлөгөөнд тусгах ажиллахад тодорхой үүрэг оролцоотой ажиллах хэрэгтэй байна. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь одоогоор МИД-ын бүтээгдэхүүнийг давхар даатгалд хамруулж байгаа тул санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны орлого хангалттай бус байх эрсдэлтэй юм. Мөн түүнчлэн малын даатгал нь сайн дурын даатгал бөгөөд малчдын хамрагдалтаас давхар даатгалын компанийн орлого шууд хамааралтай байгаа. МИД-ын бүтээгдэхүүн нь одоогоор төлөөлөгчийн сувгаар борлуулагдаж байгаа бөгөөд зардал өндөртэй тул борлуулалтын суваг нэмэгдүүлсэн байх шаардлагатай юм.

Төр засгийн шийдвэрээс үүсэх эрсдэл

Сүүлийн жилүүдэд засаглалын сул талууд өмнөх үеэсээ илүү тод харагдаж, авилга өндөртэй болж, дотоодын улс төрийн тогтворгүй байдал ихсэж, төрөөс батлагдан гарч буй хууль тогтоомжууд хэрэгжих боломжгүй эсвэл богино хугацаанд өөрчлөгдөж, аливаа эхлүүлсэн ажлууд үр дүнгээ өгөлгүй зогсож байгаа нь ихээхэн эрсдэл дагуулж байна. Түүнчлэн малчдын зүгээс хүлээлт үүсгэдэг муу талтай. Иймд, өнөөгийн нийгэм улс төрийн байдлыг

ажиглан судлаж, компанийн үйл ажиллагаатай холбогдуулан эдийн засаг болон хөдөө аж ахуйн салбартай хамааралтай хууль эрх зүйн шийдвэрүүд, тэдгээрийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, таамаглал боловсруулах зайлшгүй шаардлагатай байна.

Улсын Их Хурлын хууль тогтоомж:

- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр,
- Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал,
- Монгол Улсын 2017 оны улсын төсвийн тухай хууль,
- “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”,
- Төрөөс малчдын талаар баримтлах бодлого,
- Тариалангийн тухай хууль,
- Органик хүнсний тухай хууль, зэрэг хууль тогтоомжуудыг судлан үзэж, хөдөө аж ахуйн салбарын талаарх зүйл заалтуудад шинжилгээ хийж, хэрэгжилт болон хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах, компанийн зорилтыг биелүүлэхэд хууль хэрэгжүүлэгч бодлогын газруудтай хамтарч ажиллах талаар судлах

Мөн Улсын Их Хуралд 2012-2016 оны бүрэн эрхийн хугацаанд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлгийн шатанд байгаа “Мал, амьтны эрүүл мэндийн тухай”, “Малын генетик нөөцийн тухай” зэрэг хуулийн төслүүдийг эгүүлэн татаж, шинэ бүрэн эрхийн хугацаанд дахин өргөн мэдүүлж, батлуулахаар болсон байна. Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн Малын генетик нөөцийн тухай, Бэлчээр хамгаалах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийг тус тус боловсруулан батлуулж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхээр зорьж байна. Цаашид:

- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, дэвшилтэт техник, технологийн шинэчлэлийг хийх, инновацийг нэвтрүүлэх, түүнчлэн “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлэх, “Монгол малчин” хөтөлбөрийг боловсруулах
- Малжуулах хөтөлбөр
- Малчдыг орон сууцжуулах хөтөлбөр
- Бэлчээрийг мал аж ахуй, эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослуулан, мах, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, жилд экспортлох хэмжээг нэмэгдүүлж, малчин өрхийн орлогыг дээшлүүлэх
- Малыг бүртгэлжүүлж, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг дээшлүүлж, гарал үүслийг тодорхой болгох системийг бүрдүүлнэ. Бүртгүүлсэн мал даатгалд хамрагдсан талаар мэдээллийг давхар бүртгэлжүүлж цахимжуулах.
- *Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалт, даатгал, татварын уян хатан бодлогоор дэмжих, малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчдад ирж байгаа хүндрэлийг багасгахад чиглэгдсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих тусгай санг өргөжүүлж, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангана.*

Засгийн газрын тогтоол шийдвэр:

- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх тухай ЗГ-ын 113-р тогтоол, 2016-02-22
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр батлах тухай ЗГ-ын 114 -р тогтоол, 2016-02-22

- Малчдыг дэмжих зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 90-р тогтоол, 2016-02-04 /Хөтөлбөрийн хэрэгжилтийг ЗГ-ын 2016-8-10-ны өдрийн 33-р тогтоолоор зогсоосон/
- Хөдөө аж ахуйн салбарын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 322-р тогтоол, 2016-06-13

ХХАААҮЯ-ны дэргэд хэрэгжиж буй ХАА-н төсөл хөтөлбөрүүдийг судалж, хамтарч ажиллах талаар санал дэвшүүлэх, малчид, тариаланчдыг даатгалд хамруулах үйл явцыг тэдгээр төсөл, хөтөлбөр болон адил төстэй байгууллагуудын тусламжтайгаар буюу борлуулалтын шинэ суваг гаргахад анхаарч судлах шаардлагатай байна.

7.2. Хууль, эрх зүйн орчны эрсдэл

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь “Даатгалын тухай хууль”, “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль” болон бусад холбогдох хууль, СЗХ-ноос баталсан “Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах сангийн бүрдүүлэлт, байршуулалт, зарцуулалт, түүнд хяналт тавих журам”, “Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам”, “Малын индексжүүлсэн даатгалын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журам” болон бусад холбогдох дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Даатгалын тухай хууль нь Монгол улсад даатгалын үйл ажиллагаа явуулж байгууллагын даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг ерөнхий хууль юм.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль нь “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ны эрх зүйн орчин болон үйл ажиллагааг хуулийн хүрээнд нарийвчлан зохицуулдаг хууль билээ.

- Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль”-ийн зорилго, хамрах хүрээ нь зөвхөн малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахаар байгаа.
- “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль”-ийн давхар даатгалын компани, даатгалын гэрээ, давхар даатгалын гэрээ гэсэн ойлголтууд бүгд “Малын даатгал”, “Малын давхар даатгал” гэдгийг тодотгосон байна.
- “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль”-ийн 4.1.9 .“малын давхар даатгалын компани /цаашид “давхар даатгалын компани” гэх/ гэж энэ хуулийн 18.1-д заасан давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэн явуулах, тусгайлсан чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг” гэж тодорхойлсон нь 18.1-д заасан “Давхар даатгалын компани” гэсэн тодорхойлолт нь “малын давхар даатгалын компани” гэсэн ойлголт төдийгүй энэ заалтад заасан малын давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх, тусгайлсан чиг үүрэг бүхий гэснийг тодотгосон утга агуулга бүхий байна.

Дээрхээс харахад “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь цаашид үйл ажиллагаа тэлж, бүтээгдэхүүн үйдчилгээг нэмэгдүүлэхийн тулд “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль”-нд нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй хэрэгцээ шаардлагатай нь харагдаж байна.

Тариалангийн даатгалын хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулах

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас санаачлан Тариалангийн даатгалын хуулийн үзэл баримтлал болон хуулийн төсөл боловсруулах гэж байгаатай холбогдуулан Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн холбогдох газрын дарга, мэргэжилтнүүд хуулийн ажлын хэсэгт орж ажиллаж байна. Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн зүгээс газар тариалангийн даатгалын талаар олон улсын туршлагыг судлан судалгаа болон эдийн засгийн тооцооллыг эхний байдлаар хийсэн бөгөөд цаашид дээрх судалгаа, тооцооллыг үргэлжлүүлэн хийж, хуулийн үзэл баримтлал, төсөлд өөрийн саналаа өгч ажиллана. Ажлын хэсэг хуулийн төслийг 2017 оны 09-р сард Засгийн газарт хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

2017 онд компанийн цаашдын үйл ажиллагааны хүрээнд дараах дүрэм журмуудыг боловсруулж ажлын хэсэгт орж, холбогдох эрх бүхий газраар батлуулах.

1. Малын индексжүүлсэн даатгалын алдагдлаас хамгаалах сангийн бүрдүүлэлт, байршуулалт, зарцуулалт, түүнд хяналт тавих журамыг боловсруулж батлуулах;
2. Малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөр олгох журмыг боловсруулж батлуулах;
3. Дотоод болон гадаад давхар даатгалын зохицуулалтын бодлого, хөтөлбөр боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх;

8. ДҮГНЭЛТ

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хувьд одоогоор их хэмжээний эрсдэл хүлээх чадвар буюу нөөц хөрөнгө харьцангуй багатай байгаа тул ойрын хэдэн жилдээ давхар даатгалд хамруулсан хариуцлагын ихэнх хэсгийн ОУ-ын давхар даатгагч нарт шилжүүлэн улмаар дотоодын нөөц хөрөнгийн хамгаалах, өсгөх төлөвлөгөөтэй байна.

Хүснэгт 22. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн 2017 оны нийт борлуулалтын төлөвлөгөө

	Нийт даатгалын хураамж	ХААДД ХК-ийн нийт хураамж	ОУ Давхар даатгал	ХААДД ХК-ийн үлдэгдэл хураамж
Малын индексжүүлсэн даатгал	2,614,145,900.00	1,167,686,688.00	532,886,262.00	634,800,426.00
<i>Эрсдэлийн дээд түвшин</i>	<i>487,000,000.00</i>	<i>487,000,000.00</i>	<i>150,000,000.00</i>	<i>337,000,000.00</i>
<i>Эрсдэлийн дунд түвшин</i>	<i>2,127,145,900.00</i>	<i>680,686,688.00</i>	<i>382,886,262.00</i>	<i>297,800,426.00</i>
Газар тариалангийн бүтээгдэхүүн	43,200,000.00	41,040,000.00	34,560,000.00	6,480,000.00
Хөрөнгийн даатгал	76,000,000.00	72,200,000.00	60,800,000.00	11,400,000.00
Эрчимжсэн мал аж ахуй	36,000,000.00	34,200,000.00	28,800,000.00	5,400,000.00
Бусад	40,000,000.00	38,000,000.00	32,000,000.00	6,000,000.00
Нийт	2,733,345,900.00	1,280,926,688.00	628,246,262.00	652,680,426.00

Макро эдийн засгийн үзүүлэлт сайжирч иргэдийн худалдан авах чадвар нэмэгдэхэд манай компанийн хувьд даатгалын хураамжийн орлого нэмэгдэх хандлагатай ч зөвхөн ашигт малтмалын салбар өсөхөөр харагдаж байна. Энэ нь богино хугацаанд хөдөө аж ахуйн салбарт өсөлт харагдахгүй байх эрсдэлтэй. Иймд манай байгууллагын хувьд даатгалын хураамжийн орлого өмнөх онохоос төдийлөн өсөхгүй байх магадлалтай.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл болон мөнгөний бодлогын бусад баримт бичгээс үзэхэд бодлогын хүү буурах хандлагатай байгаа нь “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хувьд хөрөнгийн орлого (нөөц санг арилжааны банканд байршуулсан хүүгийн орлого) шууд буурах эрсдэлийг бий болгож байна. Гэхдээ, арилжааны банкнуудын зээлийн хүү буурах, банкны бүтцэд өөрчлөлт орсноор арилжааны банкны хувьд шинэ бүтээгдэхүүн бий болж хөрөнгийн орлого өсөх ч хандлага ажиглагдаж болно. Дээрхээс дүгнэвэл ХААДД ХК-ийн хөрөнгийн орлого 2017 онд тогтвортой байна гэж үзэж байна.

Монгол банк, Сангийн яамны боловсруулсан макро эдийн засгийн бодлогын баримт бичгээс үзэхэд инфляцийн түвшинг тогтвортой барихаар тусгасан байна. Энэ нь манай компанийн зарлага 2017 онд өсөх магадлал бага байна. Хэрвээ хүн амын худалдан авах чадвар нэмэгдвэл инфляцийн түвшин нэмэгдвэл урсгал зарлага өсөх эрсдэлтэй байна.